



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 18 он 10  
сарын 16 өдөр

Дугаар ЗГ-1/168

Улаанбаатар  
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
М.ЭНХБОЛД ТАНАА

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Монгол Улсын Ерөнхий сайд



У.ХҮРЭЛСҮХ

003150



МОНГОЛ УЛС  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20.18 он 10 дугаар  
сарын 09 ны өдөр

Дугаар *ХЭГ*  
*2185*

Улаанбаатар-12  
Утас: 260817  
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  
Ц.ЦОЛМОН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацаа товлох тухай

Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэх хугацааг товлож өгнө үү.

Монгол Улсын сайд,  
Засгийн газрын Хэрэг  
эрхлэх газрын дарга



Г.ЗАНДАНШАТАР



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2018.10.01 № 6/6180  
танай \_\_\_\_\_-ны № ХӨГ/2010-Т

**МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ  
ГАЗРЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР  
ТАНАА**

Радио долгионы тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль  
тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн  
20.7-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн  
мэдүүлэх зөвшөөрлийг үүгээр олгож байна.



Ч.ХҮРЭЛБААТАР

О.Батсайхан

Хэлснүүдэлт Батнох


0 1523  
17.10.18

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдааны 38 дугаар тэмдэглэлд:

“III.ХЭЛЭЛЦСЭН нь: Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дэмжиж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



## РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг. Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

#### 1.1. Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.1-д “Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн актыг боловсронгуй болгож, Монгол Улсын хууль болон олон улсын гэрээнд нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдүүлэх” гэж, 3.3.7-д “Радио долгионы зохицуулалт, төлөвлөлтийг сайжруулж, үр ашигтай хуваарилалтыг бий болгох” гэж заасан.

#### 1.2. Практик шаардлага

1. Радио долгионы тухай хууль 1999 онд батлагдснаас хойш Засгийн газрын бүтэц, чиг үүргийн өөрчлөлттэй холбогдуулан тус хуульд нэмэлт, өөрчлөлт оруулаагүй бөгөөд үүнтэй холбоотой өөрчлөлтийг хуульд тусгах шаардлагатай байна. Дэд бүтцийн яамны хариуцан хэрэгжүүлж байсан радио долгионы асуудлаарх чиг үүрэг нь одоогийн харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэгт хамаарч байна.

2. Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж эхэлсэнтэй холбоотой тус салбарын хэм хэмжээ тогтоосон актыг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих байгууллагуудыг тодорхой болгох шаардлагатай байна. Радио долгионы хуулийг хэрэгжүүлэх явцад радио долгионы хуваарилалт, ашиглалт, тусгай зөвшөөрөлтэй холбоотой дүрэм, журам, зохицуулалтын баримт бичгүүдийг батлах бүрэн эрхийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Зохицуулах байгууллагын эрх хэмжээнд тодорхой тусгаж, хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

3. Сансрын холбооны үндэсний хиймэл дагуулд ашиглах орбитын байрлал, радио давтамжийн төлөвлөлтийг Олон улсын цахилгаан холбооны байгууллагад бүртгүүлэх, радио давтамжийн координац хийхдээ тус олон улсын байгууллагын

тогтоосон журмыг баримталдаг. Энэхүү ажлыг хийж гүйцэтгэхдээ олон улсын гэрээ, конвенцийг мөрдлөг болгодог тул Монгол Улсын олон улсын гэрээнд дурдсан нэр томъёог ашиглан хуулийн нэр томъёоны тодорхойлолтод зарим өөрчлөлтийг оруулах шаардлага үүсч байна.

4. Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжснээр харилцаа холбооны салбарт төрөл бүрийн хэрэглээний радио систем, техник, технологи олноор нэвтэрснээр радио долгион ашиглах цар хүрээ асар хурдтай нэмэгдэж, тэдгээрийг зохицуулах, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах, баталгаажуулах асуудал чухлаар тавигдах болсон.

Энэхүү хуулийн төслийн хүрээнд радио долгионы ашиглалтын зөвхөн техник технологитой холбоотой асуудлыг авч үзэхээс гадна түүний хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, давтамжийн хязгаарлагдмал нөөц баялгийг үр ашигтай ашиглах, радио давтамжийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хийх, төрийн шинэлэг, бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан иргэдийн эрэлт, хэрэгцээг хангасан шинэ төрлийн хэрэглээ, үйлчилгээг нэвтрүүлэх, дэмжих эрх зүйн шинэ зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Монгол Улсын хэмжээнд батлагдсан MNS 5594:2015 “Радио давтамжтай цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшин (3 кГц -ээс 300 ГГц хүртэл)”, MNS 6499:2015 “Хүний биед ойр хэрэглэдэг утасгүй холбооны төхөөрөмжийн нөлөөллөөр үүсэх онцгой шингээлтийн хэмжээг тодорхойлох арга (30МГц-ээс 6 ГГц-ийн давтамжийн цараанд)” стандартуудын шаардлагыг хангуулах, асуудлыг шийдвэрлэх хууль, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна.

Сүүлийн үед эдгээр стандартын хүрээнд гар утасны хэрэглээ, бааз станцуудын байршил нь хүний эрүүл мэнд сөрөг нөлөө үзүүлдэг эсэх асуудлаар олон тооны гомдол, хэмжилт хийлгэх хүсэлтийг орон сууцны иргэд, байгууллага, харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч нараас ирүүлэх болсон. Үүнтэй холбоотой Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн санал, гомдол 2013 онд 60 байсан бол жилээс жилд нэмэгдсээр 2017 онд 480-д хүрсэн байна.

5. Монгол Улсын нутаг дэвсгэр дэх радио долгион үүсгэгчээс үүссэн болон үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтэд багтаж байгаа радио долгион нь Монгол Улсын төрийн өмч бөгөөд радио давтамж нь байгалийн хязгаарлагдмал нөөц баялаг юм. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуульд радио долгионы үр өгөөжийг нэмэгдүүлэх талаар зохицуулалт дутмаг байна. Олон улсын цахилгаан холбооны байгууллагын судалгаанаас харахад радио давтамжийн ашиглалтыг 10 хувь нэмэгдүүлэхэд ДНБ 0,8 дахин өсөх боломжтой гэж дүгнэсэн байдаг.

Иймд радио давтамжийн ашиглалтын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах шаардлага гарч байна.

6. 2001 оноос хойш шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулиудын өөрчлөлттэй холбоотойгоор Радио долгионы тухай хуульд өөрчлөлт

ороогүй тул Харилцаа холбооны тухай хууль болон бусад хуультай нийцүүлэн эшлэл, заалт өөрчлөх шаардлагатай байна.

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайланд эдгээр асуудлыг шийдвэрлэх шаардлагатайг зөвлөсөн байдаг.

Иймд дээр дурьдсан үндэслэл, шаардлагын хүрээнд Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

### **Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2-т заасны дагуу хуульд өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулна.

Радио долгионы тухай хуулиар радио долгионыг хуваарилах, ашиглах, хамгаалах, өмчлөх, эзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулахдаа радио долгионы ашиглалттай холбоотой зөвхөн техник, технологийн талыг авч үзэхээс гадна түүний хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, давтамжийн хязгаарлагдмал нөөц баялгийг үр дүнтэй хуваарилах, нийтийн хэрэглээний радио давтамжийн нэгдсэн бодлого, төлөвлөлт, төрийн захиргааны байгууллага, зохицуулах хорооны эрх үүргийн зааг, ялгааг тодорхой болгох, зохицуулах байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгоор хуулийн төсөлд дараахь асуудлыг тусгана. Үүнд:

1.Радио долгионы асуудлаар Засгийн газар, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо болон төрийн бус байгууллагын эрх, үүргийг зааглан тодорхой болгоно.

2.Радио долгионы хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хязгаарлахтай холбоотой хуулийн зохицуулалтыг тусгана.

3.Радио давтамжийн ашиглалтын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зохицуулалтыг тусгана.

4.Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болох Олон улсын цахилгаан холбооны байгууллагын конвенци болон Дэлхийн радио холбооны дүрмийн нэр томъёонд нийцүүлэн хуулийн зарим нэр томъёог өөрчлөн шинэчилнэ.

5.Дэлхийн радио холбооны их хурал, бүсийн бэлтгэл хуралд бэлтгэх, радио долгионы улс хоорондын зохицуулалт хийх, шинэ техник, технологийг нэвтрүүлэх хандлага, хэрэгжүүлэх зарчмыг тогтоох, мэргэжлийн санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус мэргэжлийн зөвлөл байгуулах, түүний эрх зүйн байдлыг тодорхойлно.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хуулийн төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгмийн дараахь үр дагавар гарна гэж үзэж байна.Үүнд:

1.Радио долгионы бодлого зохицуулалт, төлөвлөлтийг сайжруулж, радио давтамжийн үр ашигтай хуваарилалтыг бий болгон байгалийн хязгаарлагдмал нөөцийг зүй зохистой ашигласнаар шинэ үйлчилгээ, техник, технологийг нэвтрүүлэх үйл явц хурдсаж, эдийн засаг, нийгмийн хөгжилд эерэг нөлөө үзүүлнэ.

2.Радио холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийг баталгаажуулснаар радио долгионы хортой нөлөөллөөс хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаална.

3.Радио давтамжийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх өндөр технологийн судалгаа шинжилгээ, үйлдвэрлэлийг дэмжих хуулийн зохицуулалт тодорхой болсноор өндөр технологи, мэдлэгт тулгуурласан эдийн засгийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах боломжтой болно.

4.Дэлхийн радио холбооны дүрэм, журамд радио долгионы талаархи эрх зүйн баримт бичгийг нийцүүлснээр олон улсын нийтлэг нэр томъёог хэрэглэж, нэгдмэл ойлголт бий болно.

5.Дэлхийн радио холбооны их хурал, бүсийн бэлтгэл хуралд бэлтгэх, радио долгионы улс хоорондын зохицуулалт хийх, шинэ техник, технологийг нэвтрүүлэх чиг хандлага, хэрэгжүүлэх зарчмыг тогтоох мэргэжлийн санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий зөвлөл байгуулсанаар эдийн засгийн бодит өсөлтийг дэмжсэн шинэ техник, технологи нэвтрэлтийг түргэсгэх, хөрөнгө оруулалт, шинэ ажлын байр бий болгоход дэмжлэг үзүүлэх боломжтой болно.

6.Хуулийн зарим зүйл, заалтын давхардал, хийдэл, зөрчил арилна.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд холбогдуулан шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаархи санал**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд хуулийн төслийг Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй уялдуулан боловсруулна.



## **РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 47 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын 3.2.1-д “Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн актыг боловсронгуй болгож, Монгол Улсын хууль болон олон улсын гэрээнд нийцүүлэн шинэчлэн боловсруулж мөрдүүлэх” гэж, 3.3.7-д “Радио долгионы зохицуулалт, төлөвлөлтийг сайжруулж, үр ашигтай хуваарилалтыг бий болгох” гэж заасныг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Засгийн газраас санаачлан Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судлах судалгаа болон хуулийн төслийн үзэл баримтлалыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, их, дээд сургуулийн эрдэмтэн судлаачид, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг боловсруулсан. Уг ажлын хэсгийн хүрээнд 3 судалгааны хэсэг ажиллаж, холбогдох төрийн болон хувийн хэвшлийн 30 гаруй байгууллагаас судалгаа авч, 77 улсын Радио долгионы тухай хууль тогтоомжийг судалсан.

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд заасны дагуу радио долгионы салбарын хэмжээнд дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон актыг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих байгууллагыг тодорхой болгох, радио долгионы хуваарилалт, ашиглалт, тусгай зөвшөөрөлтэй холбоотой дүрэм, журам, зохицуулалтын баримт бичгүүдийг батлах бүрэн эрхийг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрхэд хамааруулах, Радио долгионы хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах, түүнд хяналт тавих, давтамжийн хязгаарлагдмал нөөц баялгийг үр ашигтай ашиглах, радио давтамжийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хийх, төрийн шинэлэг, бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан иргэдийн эрэлт, хэрэгцээг хангасан шинэ төрлийн хэрэглээ, үйлчилгээг нэвтрүүлэх, дэмжих эрх зүйн орчныг бий болгох зорилгоор Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

Түүнчлэн 2001 оноос хойш шинээр батлагдсан болон нэмэлт, өөрчлөлт оруулсан хуулиудын өөрчлөлттэй холбоотойгоор Радио долгионы тухай хуульд өөрчлөлт оруулаагүй байсан тул Харилцаа холбооны тухай хууль болон бусад хуультай нийцүүлэн эшлэл, заалтуудыг өөрчлөх, Олон улсын цахилгаан холбооны байгууллагын конвенци болон Дэлхийн радио холбооны дүрмийн нэр томъёонд нийцүүлэн хуулийн зарим нэр томъёог өөрчлөх шаардлага үүсээд байсан юм.

Уг хуулийн төсөл нь 7 зүйлтэй.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр хуульд дараахь нэмэлт оруулахаар тусгасан. Үүнд:

-Нэг, эсхүл хоёр чиглэлд радио холбоо хийх, бусад радио холбоонд нөлөөлөхгүй, нөлөөллийн хамгаалалт шаардлагагүй, бага энерги хэрэглэх радио нэвтрүүлэгчийг "богино зайн радио төхөөрөмж" гэж, радио холбооны үйлчилгээнд хөндлөнгөөс зориудаар шуугиан үүсгэн дохио дарагч төхөөрөмжийг "радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж" гэж ойлгоно гэсэн нэр томъёоны тодорхойлолтыг хуулийн 3 дугаар зүйлд нэмсэн.

-Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхэд үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт, радио долгионы төлөвлөлтийн бодлого, стратеги, шинэ технологи нэвтрүүлэх, хөгжүүлэхэд баримтлах чиглэл батлах, хуваарилсан сансарын холбооны хиймэл дагуулын байрлалыг ашиглах талаар санал болон төрийн нууцад хамаарах радио давтамжийн хуваарилалтын мэдээллийг боловсруулах бүрэн эрхийг нэмж оруулсан.

-Хуулийн төсөлд "Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрх" гэсэн 5<sup>1</sup> дүгээр зүйл шинээр нэмж, радио долгионы талаархи Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрхийг зааж өгсөн. Тухайлбал, Харилцаа холбооны зохицуулах хороо нь радио долгионы талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, хэрэгжилтэд нь дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах, радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, радио давтамжид баримтлах зохицуулалт, радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норматив баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих, улс орны зайлшгүй хэрэгцээ болон техник, технологийн шинэ дэвшлийг нэвтрүүлэхэд шаардагдах радио давтамжийн зурвасын судалгаа хийх, Монгол Улсад бүртгэлтэй болон бүртгүүлэхээр төлөвлөж байгаа радио давтамж, радио давтамжийн зурвасыг олон улсын цахилгаан холбооны байгууллагад бүртгүүлэх, радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах журам батлах, хяналт тавих зэрэг болно.

-Хуулийн төсөлд нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасын хуваарилалт, төлөвлөлт нийтэд нээлттэй байхаар тусгасан.

-Хуульд өөрөөр заагаагүй бол радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах, импортлох, үйлдвэрлэх, худалдах болон иргэн, хуулийн этгээд тохирлын баталгаагүй радио тоног төхөөрөмж ашиглахыг тус тус хориглох зохицуулалтыг хуулийн 8 дугаар зүйлд нэмсэн.

-Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн нэгдсэн бүртгэлийн журмыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга, радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журмыг Зохицуулах хороо тус тус батлахаар тусгасан.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хийсэн Давхардал, хийдэл, зөрчлийн судалгааны тайланд тулгуурлан зарим нэр томъёо, зохицуулалтыг Монгол Улсын олон улсын гэрээ, жишигт нийцүүлэх, хуулийн зүйл, заалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг хэл зүй, найруулгын тухайд ойлгомжтой, тодорхой болгох үүднээс хуулийн төслийн **2 дугаар зүйлд** хуульд нэмж

оруулах үг хэллэг, нэр томъёог, **4 дүгээр зүйлд** өөрчилсөн үг хэллэг, нэр томъёо, зүйл, заалтын дугаарлалттай холбоотой өөрчөлтийг тус тус тусгасан.

Хуулийн төслийн **3 дугаар зүйлд** техникийн шаардлага хангасан, тохирлын гэрчилгээтэй богино зайн радио төхөөрөмжийг ашиглахад тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг шаардахгүй байхаар хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтыг өөрчлөн найруулахаар тусгаж, **5 дугаар зүйлд** “харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэснийг “харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” болгосон өөрчлөлтийг, **6 дугаар зүйлд** хүчингүй болсонд тооцох заалтыг тус тус тусгасан болно.

Олон нийтээс санал авах зорилгоор Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаархи хэлэлцүүлгийг Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамтад нь 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд, 2018 оны 02 дугаар сарын 23-ны өдөр Харилцаа холбооны салбарын удирдах ажилтны зөвлөгөөний үеэр тус тус зохион байгуулсан бөгөөд хуулийн төсөлтэй холбоотойгоор давхардсан тоогоор 71 санал ирүүлснийг судлан үзэж, хуулийн төслийн үзэл баримтлалд нийцүүлэн холбогдох саналыг хуулийн төсөлд тусгалаа.

Мөн санал авах зорилгоор хуулийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны цахим хуудсуудад байршуулсан бөгөөд тусгайлсан санал ирээгүй болно.

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хууль тогтоомжтой нийцсэн бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

-ooOoo-

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Радио долгионы тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/3 дугаар зүйлийн 3.1.5, 3.1.6 дахь заалт:**

“3.1.5.“богино зайн радио төхөөрөмж” гэж нэг, эсхүл хоёр чиглэлд радио холбоо хийх, бусад радио холбоонд нөлөөлөхгүй, нөлөөллийн хамгаалалт шаардлагагүй, бага энерги хэрэглэх радио нэвтрүүлэгчийг;

3.1.6.“радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж” гэж радио холбооны үйлчилгээнд хөндлөнгөөс зориудаар шуугиан үүсгэн дохио дарагч төхөөрөмжийг.”

#### **2/5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалт:**

“5.1.3 хуульд заасан бусад бүрэн эрх.”

#### **3/5 дугаар зүйлийн 5.2.6-5.2.10 дахь заалт:**

“5.2.6.үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт батлах;  
5.2.7.радио долгионы төлөвлөлтийн бодлого, стратеги, шинэ технологи нэвтрүүлэх, хөгжүүлэхэд баримтлах чиглэл батлах, хэрэгжилтийг хангуулах;

5.2.8.Монгол Улсад хуваарилсан сансарын холбооны хиймэл дагуулын байрлалыг ашиглах талаар санал боловсруулах;

5.2.9.төрийн нууцад хамаарах радио давтамжийн хуваарилалтын мэдээллийг боловсруулах;

5.2.10.хуульд заасан бусад бүрэн эрх.”

#### **4/5<sup>1</sup> дүгээр зүйл:**

## **"5<sup>1</sup> дүгээр зүйл. Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрх**

5<sup>1.1</sup>.Харилцаа холбооны зохицуулах хороо радио долгионы талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5<sup>1.1.1</sup>.радио долгионы талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, хэрэгжилтэд нь дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;

5<sup>1.1.2</sup>.радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, радио давтамжид баримтлах зохицуулалт, радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норматив баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

5<sup>1.1.3</sup>.улс орны зайлшгүй хэрэгцээ болон техник, технологийн шинэ дэвшлийг нэвтрүүлэхэд шаардагдах радио давтамжийн зурвасын судалгаа хийх, нөөцийг бүрдүүлэх;

5<sup>1.1.4</sup>.Монгол Улсад радио долгионы хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх;

5<sup>1.1.5</sup>.Монгол Улсад бүртгэлтэй болон бүртгүүлэхээр төлөвлөж байгаа радио давтамж, радио давтамжийн зурвасыг олон улсын цахилгаан холбооны байгууллагад бүртгүүлэх;

5<sup>1.1.6</sup>.тусгай хэрэглээнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, зохицуулалтын баримт бичгийг тусгай хэрэглээний радио давтамж ашиглах эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулах;

5<sup>1.1.7</sup>.цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшний хэмжилт хийх аргачлалыг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

5<sup>1.1.8</sup>.хуульд заасан тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, тохирлын гэрчилгээ олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, зохицуулалтын баримт бичиг болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;

5<sup>1.1.9</sup>.радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах журам батлах, хяналт тавих;

5<sup>1.1.10</sup>.хуульд заасан бусад бүрэн эрх."

**5/6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг:**

"6.4.Нийтийн хэрэглээний радио давтамжийн зурвасын хуваарилалт, төлөвлөлт нийтэд нээлттэй байна."

**6/8 дугаар зүйлийн 8.2-8.3 дахь хэсэг:**

“8.2.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд тохирлын баталгаагүй радио тоног төхөөрөмж ашиглахыг хориглоно.

8.3.Хуульд өөрөөр заагаагүй бол радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах, импортлох, үйлдвэрлэх, худалдахыг хориглоно.”

#### **7/15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэг:**

“15.3.Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн нэгдсэн бүртгэлийн журмыг харилцаа холбооны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална.”

#### **8/20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсэг:**

“20.6.Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журмыг Зохицуулах хороо баталж, мөрдүүлнэ.”

**2 дугаар зүйл.**Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “долгионы” гэсний өмнө “радио” гэж, 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалтын “төлөөлөх” гэсний дараа “, олон улсын болон бүсийн хуралд бэлтгэх, оролцохтой холбогдсон болон олон улсын гишүүн орнуудаас урьдчилан гаргасан санал, дүгнэлт, судалгааны үр дүнг судлах ажлыг зохион байгуулах” гэж, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсгийн “аюулгүй байдлыг хангах,” гэсний дараа “гамшгаас хамгаалах,” гэж, 8 дугаар зүйлийн гарчгийн “зурвас” гэсний дараа “, радио төхөөрөмж” гэж, 11 дүгээр зүйлийн 11.2.2 дахь заалтын “тухайн” гэсний өмнө “Харилцаа холбооны тухай хуулийн 14.2-т заасан үндэслэлээр, эсхүл” гэж, 14 дүгээр зүйлийн 14.1.2 дахь заалтын “эмчилгээ, оношилгооны” гэсний өмнө “үйлдвэрлэл, шинжлэх ухаан ба” гэж, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “стандартын дагуу” гэсний дараа “баталгаажуулалт хийх ба баталгаажуулалтын” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Радио долгионы тухай хуулийн дараахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт:**

“5.2.3.радио давтамжийн зурвасыг ашиглах, төлөвлөх, дахин төлөвлөх, хуваарилах болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр тогтоох журам батлах;”

#### **2/14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалт:**

“14.1.3.техникийн шаардлага хангасан, тохирлын гэрчилгээтэй богино зайн радио төхөөрөмж.”

**4 дүгээр зүйл.**Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийн “эрхэлсэн” гэснийг “хариуцсан” гэж, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн “9.2-

т" гэснийг "13.2-т" гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн "11-д заасны дагуу ашиглана" гэснийг "11.1-д заасны дагуу ашиглах зөвшөөрөл олгоно" гэж, 11.4 дэх хэсгийн "өрсөлдүүлэн" гэснийг "сонгон" гэж, "олгож болно" гэснийг "олгоно" гэж, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн "15" гэснийг "20" гэж, 12.2 дахь хэсгийн "60 ба түүнээс дээш хоногийн өмнө" гэснийг "60 хоногийн дотор" гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн "эрхэлсэн" гэснийг "хариуцсан" гэж, 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн "11-д" гэснийг, "15.1-д" гэж, 18 дугаар зүйлийн гарчиг, мөн зүйлийн 18.2 дахь хэсгийн "цуцлах" гэснийг "хүчингүй болгох" гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн "12-т" гэснийг "15.1-д" гэж, 18.1, 18.5 дахь хэсгийн "цуцална" гэснийг "хүчингүй болгоно" гэж, 18.6 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.2.7 дахь заалтын "цуцалсан" гэснийг "хүчингүй болгосон" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийн "төв" гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, мөн зүйлийн 5.2.4 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.** Энэ хуулийг ... оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2018 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 14.2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 7 дахь хэсэг нэмсүгэй:

“7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрөл болон түүнд заасан эрх, үүргээ тусгай зөвшөөрөл олгосон байгууллагын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлсэн бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2018 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг





МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗАР  
WWW.ICT.MN



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

**РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН  
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫН УРЬДЧИЛСАН ТАНДАН  
СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

2017 он

## УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас мэдээллийн технологи, харилцаа холбоо (цахилгаан холбоо, радио телевиз, шуудан, мэдээллийн технологийн бүх төрлийг)-ны салбарын хөгжил нь Монгол Улсын тогтвортой хөгжил, хүний хөгжлийг хурдасгагч, мэдлэгт суурилсан нийгэм байгуулах, дэмжих чухал хэрэгсэл хөшүүрэг гэж үзэж байгаа өнөө үед шинэ техник технологийг нэвтрүүлэх, салбарын хөгжлийн гол тулгууруудын нэг болсон радио давтамжийн бодлого, зохицуулалтыг оновчтой явуулах, байгалийн хязгаарлагдмал нөөц баялаг болсон радио долгионы ашиглалтыг нэмэгдүүлэх, бий болсон нэмэлт орлогоор мэдлэгт суурилсан эдийн засгийн хөгжлийг дэмжих судалгаа шинжилгээ, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх, улмаар радио давтамжийн хэрэглээ шаарддаг Үндэсний хиймэл дагуул хөтөлбөр зэрэг томоохон төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь тулгамдсан асуудал болоод байна.

Дэлхийн Радиохолбооны Их хурлаас баталдаг Дэлхийн Радиогийн Дүрэм буюу Монгол Улсын олон улсын гэрээ нь 3-4 жил тутам шинэчлэгддэг ба энэхүү гэрээгээр радио долгионы талаарх олон улсын бодлого, зохицуулалтыг техник технологийн хөгжилтэй уялдуулан шинэчилдэг. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан *“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 он”* баримт бичиг, хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль, тогтоомжийг *Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх*, Засгийн газрын газраас 2017 оны 47 тоот тогтоолоор *“Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”*-ын алсын хараа, зорилго, бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, *салбарын хөгжлийг олон улсын жишигт хүргэх, олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх* зэрэг нь хууль эрх зүйн орчиныг боловсронгуй болгох, Радио долгионы тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үндэслэл шаардлага болсон юм.

Радио долгионыг хуваарилах, ашиглах, хамгаалах, өмчлөх, эзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулахдаа радио долгионы техник технологитой холбоотой асуудлыг авч үзэхээс гадна түүний хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, байгалийн хязгаарлагдмал нөөц баялагыг үр ашигтай ашиглах, нийтийн хэрэглээний радио давтамжийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хийх, төрийн захиргааны байгууллага, зохицуулах хорооны үйл ажиллагааг бэхжүүлэх, төрийн шинэлэг бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан иргэдийн эрэлт, хэрэгцээг хангасан шинэ төрлийн хэрэглээ, үйлчилгээг нэвтрүүлэх, дэмжих эрх зүйн шинэ зохицуулалтыг шаардаж байна.

Мэдээлэл, харилцаа холбооны салбарын зөв оновчтой тодорхойлсон эрхзүйн баримт бичгүүд, хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх орчинг хэрхэн бүрдүүлснээс тухайн улсын харилцаа холбооны салбарын хөгжлийн түвшин, бизнесын орчин, төр ба хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаа хамаарч байдаг гэж судлаач, мэргэжилтнүүд үздэг байна.

Энэхүү судалгааны зорилго нь Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлого, *“Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”*-ын баримт бичиг шинээр батлагдсан, Захиргааны ерөнхий хуульд салбарын эрх зүйн орчинг нийцүүлэх, мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хөгжлийн хурдтай байдал, шинэ технологи, үйлчилгээ хэрэглээний нэвтрэлт, салбарын нэгдсэн бодлого, зохицуулалтыг

боловсронгуй болгох зэрэг чиглэлээр урьд хийгдсэн судалгааны ажил болон олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмж, мэргэжилтнүүдийн саналд тулгуурлан Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг тодорхойлон, уг асуудлыг шийдвэрлэх зорилго, арга замыг тогтоон, тэдгээрийн эерэг ба сөрөг тал, үр нөлөөг болон ижил төрлийн асуудлыг олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтаар хэрхэн шийдвэрлэснийг харьцуулан судалж, хууль тогтоомж боловсруулах хэрэгцээ шаардлагыг тандан судлахад оршино.

#### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН:

Ц. Гантөгс	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Харилцаа холбоо, шуудангийн бодлого зохицуулалтын хэлтсийн Сансрын холбооны албаны дарга
З. Амгалан	Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын дарга
М. Наранбаатар	Харилцаа холбооны зохицуулах хорооны Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газрын ахлах мэргэжилтэн
Л. Банзрагч	Мэдээлэл, холбооны технологийн салбарын Зөвлөх инженер
Э. Балдансамбуу	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Харилцаа холбоо, шуудангийн бодлого зохицуулалтын хэлтсийн Сансрын холбооны албаны мэргэжилтэн
С. Онончимэг (Ph.D)	Мөн газрын Харилцаа холбоо, шуудангийн бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

#### Судалгааны хэсгийн гишүүд:

А. Лувсан-Очир	Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил, зохицуулалтын хэлтсийн дарга
А. Уранчимэг	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын Харилцаа холбоо, шуудангийн бодлого зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Ш. Очирхүү	Мөн газрын Бүх нийтийн үүргийн үйлчилгээний сангийн ахлах мэргэжилтэн

Г. Болорчимэг	Мөн газрын Радио, телевиз, нийгмийн мэдээллийн сүлжээний бодлого, зохицуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн
Ц. Бүрэнжаргал	Харилцаа холбооны зохицуулах хорооны Захиргаа удирдлага, хамтын ажиллагааны газрын Хамтын ажиллагаа, харилцагчийн хэлтсийн мэргэжилтэн
Л. Туул	Радио, телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ын Тоон систем, хэмжилт, засварын албаны ахлах инженер
Н. Эрдэнхүү (Ph.D)	Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн Холбооны салбарын эрхлэгч

## АГУУЛГА

УДИРТГАЛ .....	1
Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалгааны ажлын арга зүй .....	5
НЭГ. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	
1.1. Бодлого, зохицуулалтын дотоод орчины шинжилгээ .....	7
1.2. Бодлого, зохицуулалтын гадаад орчины шинжилгээ ба нөлөөлөл .....	7
ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ .....	8
ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ .....	8
ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ ...	14
4.1. Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөө .....	14
4.2. Монгол улсын үндсэн хууль, монгол улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх .....	14
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ .....	15
ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ .....	16
ДОЛОО. ХУУЛИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗӨВЛӨМЖҮҮД .....	33
ХАВСРАЛТ:	
Хавсралт-1. Хуулийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгааны нэгтгэсэн хүснэгт .....	34
Хавсралт-2. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал, харьцуулалт .....	38

## **ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛГААНЫ АЖЛЫН АРГА ЗҮЙ**

Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах ажлын зорилт нь тодорхой асуудлыг шийдвэрлэх зохицуулалтын хувилбарыг тодорхойлж, эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсны үндсэн дээр үр нөлөөг урьдчилан тооцож, уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг хууль санаачлагчид санал болгоно.

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Хууль тогтоомжийн тухай хуулийг баталсан бөгөөд 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль тогтоомжийн төсөл боловсруулахад шинжлэх ухааны үндэслэлтэй, судалгаатай хандах, тухайн харилцааг заавал хуулиар зохицуулах шаардлагатай эсэх, хэрэгжүүлэх боломж нөхцөл, холбогдон гарах зардал, хууль зүй, нийгэм эдийн засагт нөлөөг сайтар судлах, хуулийн хэрэгцээ шаардлагыг тандан судлахаас эхлээд төсөл боловсруулах үе шатыг тодорхойлж, хүчин төгөлдөр хуулийн хэрэгжилт, түүний үр дагаварт хяналт, шинжилгээ үнэлгээ хийх зохицуулалтыг тусгасан болно.

Засгийн газраас энэхүү хуульд нэр заасан 6 аргачлалыг боловсруулж, 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 тоот тогтоолын хавсралтаар баталсан. Аргачлалаар өөр хоорондоо холбоос бүхий дараалсан процесс, ажиллагааг нарийвчлан тодорхойлж өгсөн юм.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйл (Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах)-д Засгийн газрын 2016 оны 59 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт болох “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу 7 үндсэн үе шатны дагуу заавал тандан судалгааг гүйцэтгэхийг заасан.

ХХМТГ-ын Дарга, ХХЗХ-ны Дарга нарын 2017 оны А/171, А/52 тоот “Ажлын хэсэг байгуулах тухай” хамтарсан тушаалын 3 дугаар хавсралтаар байгуулагдсан ажлын хэсэг болон 3 судалгааны хэсгүүд хамтран Хууль тогтоомжийн тухай 2016 оны хууль, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1-6 дугаар хавсралтууд, ХЗДХЯ-ны тушаалаар баталсан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судлах гарын авлагад заасан арга зүйг хэрэглэж, процессыг баримтлан гүйцэтгэсэн.

Ажлын хэсгээр судалгааны хэсгүүдээс ирүүлсэн тайлан, дүгнэлт зөвлөмжийг нарийвчлан ярилцаж, асуудлыг томъёолон боловсруулж, Засгийн газрын 2016 оны 59 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт болох “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу хуулийн урьдчилан тандан судлах ажлыг дараахь үе шаттай зохион байгуулсан. Үүнд:

1. асуудалд дүн шинжилгээ хийх (3 заалтын дагуу буюу үе шат, 3 дэд хэсэг);
2. асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох (3 үе шат);
3. тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах (11 үе шат, 14 дэд хэсэг);

4. зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах (8 үе шат, 3 дэд хэсэг, 4 хүснэгт);
5. зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх (1 үе шат);
6. тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх (4 үе шат, 3 дэд хэсэг);
7. зөвлөмж боловсруулах (2 үе шат) зэрэг болно.

Ажлын хэсгээс дээрх 7 үе шат, процессын хүрээнд гүйцэтгэсэн хуулийн хэрэгцээ шаардлагыг тандан судалгааны үр дүнг нэгтгэн тайлангийн хавсралт-1-д нэгтгэн үзүүлэв. Асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулах үзэх ажлын хүрээнд зорилгыг биелүүлэхэд чиглэсэн зохицуулалтын хувилбаруудыг тогтооно. Зохицуулалтын дараах хувилбаруудыг заавал авч үзсэн:

1. “тэг” хувилбар [5] буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах;
2. хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;
3. зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх;
4. төрөөс санхүүгийн интервенц хийх;
5. төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх;
6. захиргааны шийдвэр гаргах [6];
7. хууль тогтоомжийн төсөл боловсруулах.

Зөвлөмж боловсруулах үе шатанд асуудалд дүн шинжилгээ хийж, зохицуулалтын хувилбаруудыг сонгож тандан судлах явцад тухайн асуудлыг Засгийн газрын 2016 оны 59 тоот тогтоолын 6 дугаар хавсралт буюу “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу хийсэн үнэлгээнээс тухайн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэсэн зөвлөмж гарсан тул хууль тогтоомжийн төслийн бүтэц, агуулга, нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр боловсруулах шаардлагатай хууль тогтоомжийг ерөнхий байдлаар томъёолов.

Зөвлөмжид тусгах саналыг гарын авлага болгон Хавсралт-3-д нэгтгэн үзүүлсэн болно.

Урьдчилан тандан судлах ажлын тайлан, зөвлөмжийг хууль санаачлагчид хүргүүлнэ.

## **НЭГ. АСУУДЛЫН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

### **1.1. Бодлого, зохицуулалтын дотоод орчины шинжилгээ**

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан *“Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 он”* баримт бичиг, хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль, тогтоомжийг *Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх*, Засгийн газрын газраас 2017 оны 47 тоот тогтоолоор *“Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого”*-ын алсын хараа, зорилго, бодлогын зорилтыг хэрэгжүүлэх, салбарын хөгжлийг олон улсын жишигт хүргэх, олон улсын байгууллагын өмнө хүлээсэн үүргийг бүрэн хэрэгжүүлэх зэрэг нь хууль эрх зүйн орчиныг боловсронгуй болгох, Радио долгионы тухай хуульд өөрчлөлт оруулах үндэслэл шаардлагыг бий болгож байна. Түүнчлэн УИХ-ын 11 тоот тогтоолоор 2017 оны 1 сард баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар тусгасан нь Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцлийг бүрдүүлж байгаа юм.


Монгол Улсын Их Хурлаас 1999 онд Радио долгионы тухай хуулийг баталж, нийтдээ 2 удаагийн нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөж байгаа билээ. Дэлхийн радио холбооны салбарт гарч байгаа үсрэнгүй хөгжил нь улс орнуудын мэдээлэл, харилцаа холбооны зах зээлд төдийгүй нийгмийн амьдалд хүчтэй нөлөө үзүүлж байна. Үүний нэг жишээ нь гар утасны хэрэглээ мөн.

Иймд радио долгионыг хуваарилах, ашиглах, хамгаалах, өмчлөх, эзэмшихтэй холбогдсон харилцааг зохицуулахдаа радио долгионы зөвхөн техник технологитой холбоотой асуудлыг авч үзэхээс гадна түүний хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, байгалийн хязгаарлагдмал нөөц баялагыг үр ашигтай ашиглах, нийтийн хэрэглээний радио давтамжийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хийх, тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын тогтолцоог бий болгох, төрийн захиргааны байгууллага, зохицуулах хорооны үйл ажиллагааг бэхжүүлэх, төрийн шинэлэг бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан иргэдийн эрэлт, хэрэгцээг хангасан шинэ төрлийн хэрэглээ, үйлчилгээг нэвтрүүлэх, дэмжих эрх зүйн шинэ зохицуулалтыг шаардаж байна.

### **1.2. Бодлого, зохицуулалтын гадаад орчины шинжилгээ ба нөлөөлөл**

Олон Улсын Цахилгаан Холбооны Байгууллага (ОУЦХБ) нь суурин, хөдөлгөөнт, өргөн нэвтрүүлэг, сонирхогчдын холбоо, сансар судлал, гамшгийн үеийн холбоо, цаг уур, глобал байрлал тодорхойлох систем, байгалийн орчны ажиглалтанд хэрэглэгдэж байгаа байгалийн хязгаарлагдмал нөөц баялаг болох радио давтамжийн спектр болон хиймэл дагуулын орбитийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хийж байдаг. Монгол улс радио давтамжийн хуваарилалтын хувьд I-р бүсэд хамаардаг.





Зураг 1. ОУЦХБ-ын радио давтамжийн бүсүүд

Дэлхийн радио холбооны салбарт гарч байгаа шинэчлэл өөрчлөлт нь улс орнуудын радио холбооны зах зээлд төдийгүй мэдээлэл, харилцаа холбооны салбарт үлэмж нөлөө үзүүлж байдаг. Радио долгион ашиглагч техник технологийн хөгжлийн олон улсын бодлого, зохицуулалтаар цаг алдалгүй хангах нь дэлхий нийтийн томоохон зорилт байдаг бөгөөд Дэлхийн Радиохолбооны Их хурлаас баталдаг Дэлхийн Радиогийн Дүрэм буюу Монгол Улсын олон улсын гэрээ нь 3-4 жил тутам шинэчлэгддэг ба энэхүү гэрээгээр радио долгионы талаарх олон улсын бодлого, зохицуулалтыг техник технологийн хөгжилтэй уялдуулан шинэчилж байдаг. Хамгийн сүүлд Дэлхийн Радиохолбооны Их Хуралд 2015 оны 11-р сард хуралдсан бөгөөд 2016 онд Монгол улсын олон гэрээ болох Дэлхийн Радиогийн Дүрэм шинэчлэгдэн батлагдсан юм.

Дэлхийн радиогийн дүрэм шинэчлэгдэн батлагдсан тул улс орнууд радио долгионы талаарх дотоодын хууль дүрмэндээ зохих өөрчлөлтүүдийг оруулсаар ирлээ. Манай улсын хувьд Үндэсний радио давтамжийн хүснэгт шинэчлэх, радио долгионы бодлого төлөвлөлтөө шинэчлэн батлах ажлыг эхлүүлээд байна.

#### **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Судалгааны хэсгүүдээс боловсруулсан зөвлөмж, дүгнэлтийг багцлан тулгамдсан 5 асуудлыг тодорхойлж, эдгээр асуудлыг шийдвэрлэх зорилгыг радио долгионыг хуваарилах, ашиглах, хамгаалах, өмчлөх, эзэмшихтэй холбогдсон харилцааны эрх зүйн орчины өнөөгийн тулгамдсан асуудлыг цогцоор шийдвэрлэх хуулийн зохицуулалтыг хийхээр тодорхойлов.

#### **ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫН ХАРЬЦУУЛАЛТ**

Энэхүү судалгааны 1 дэх хэсэгт тодорхойлсон асуудал, түүнийг үүсгэж буй шалтгаан нөхцлийг арилгах арга замын хувилбарыг Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах "Радио долгионыг хуваарилах, ашиглах, хамгаалах, өмчлөх, эзэмшихтэй холбогдсон харилцааны эрх зүйн орчины өнөөгийн тулгамдсан асуудлыг цогцоор шийдвэрлэх

зохицуулалтыг хуульчилах" зорилгод хүрэх байдал, зардал үр өгөөж, үр нөлөөний байдлаар дараах байдлаар тулгамдсан асуудлыг зохицуулах хувилбарыг асуудал бүрээр харьцуулан үзэв (Хавсралт-1). Үүнд:

- Асуудал 1. Радио долгионы асуудлаар Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон зохицуулах хорооны эрх, үүргийг оновчтой болгох;
- Асуудал 2. Радио соронзон долгионы хүний эрүүл мэнд, хүрээлэн буй байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хязгаарлах эрх зүйн орчинг бүрдүүлэх;
- Асуудал 3. Байгалийн хязгаарлагдмал нөөц баялаг болох радио давтамжийн эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх;
- Асуудал 4. Дэлхийн радио холбооны их хурал, бүсийн бэлтгэл хурлуудад бэлтгэх, радио долгионы улс хоорондын зохицуулалт хийх, шинэ техник технологийг нэвтрүүлэх чиг хандлага, хэрэгжүүлэх зарчмыг тогтоох талаар мэргэжлийн санал дүгнэлт гаргах “Радио давтамжийн менежментийн зөвлөл” байгуулах;
- Асуудал 5. Радио долгионы тухай хуулийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх;

Дээрх асуудлуудыг шийдвэрлэх хувилбаруудыг тус бүрээр авч харьцуулж тоймлон үзвэл:

**Асуудал 1.** Радио долгионы асуудлаар Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон зохицуулах хорооны эрх, үүргийг оновчтой болгох.

№	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Радио долгионы бодлого зохицуулалт төлөвлөлтийг оновчтой хийхэд хүндрэлтэй байдал хэвээр үргэлжилнэ. Ингэснээр радио долгионы үр ашигтай хуваарилалтыг бий болгон байгалийн хязгаарлагдмал нөөцийг зүй зохистой ашиглан нийгэм эдийн засагт үзүүлэх эерэг нөлөө багасна. Шинэ үйлчилгээ, техник технологийг нэвтрүүлэх үйл явц удааширна.	Зардал гарахгүй боловч асуудлаас үүдэн бий болж байгаа сөрөг үр дагавар үргэлжилнэ.	Үр дүнгүй.
2	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Зорилгод богино хугацаанд шууд хүрэх боломжгүй. Радио долгионы бодлого зохицуулалт төлөвлөлтийг сурталчилгаа хийх замаар сайжруулах боломжгүй.	Хэвлэл мэдээлэл, олон нийтэд таниулах зорилготой холбоотой сургалт, нэвтрүүлэг ухуулга хийх нэмэлт зардал гарах боловч энэ талаар хийгдэж буй арга хэмжээ эерэг үр дагаварыг шууд богино хугацаанд үүсгэхгүй.	Үр дүнгүй.
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй	Үр дүнгүй.

	зохицуулалт хийх			
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй	Үр дүнгүй.
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Төрийн бус байгууллага, хувийн хэвшил нь радио долгионы бодлого зохицуулалт төлөвлөлтийг гаргах хэрэгжүүлэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй	Үр дүнгүй.
6	Захиргааны шийдвэр гаргах	Асуудал нь хуулийн зохицуулалтаас үүдэлтэй бөгөөд захиргааны шийдвэр гаргах замаар шийдвэрлэгдэхгүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Үүсээд байгаа шалтгаан нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтаас үүдэлтэй бөгөөд хуулийн хүчин чадлаас дээгүүр захиргааны шийдвэр гарахгүй тул зардал үр өгөөж тооцох боломжгүй.	Үр дүнгүй.
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Радио долгионы асуудлаар Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон зохицуулах хорооны эрх, үүргийг оновчтой болгох хуулийн зохицуулалт хийснээр зорилго хангагдана.	Нэмэлт зардал гарах боловч радио долгионы бодлого зохицуулалт төлөвлөлтийг сайжруулж, үр ашигтай хуваарилалтыг бий болгон байгалийн хязгаарлагдмал нөөцийг зүй зохистой ашигласнаар нийгэм эдийн засгийн үр өгөөж нэмэгдэнэ.	Үр дүнтэй.

Асуудал 2. Радио соронзон долгионы хүний эрүүл мэнд, хүрээлэн буй байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хязгаарлах эрх зүйн орчинг бүрдүүлэх.

№	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	“Тэг” хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Радио соронзон долгионы нөлөөллөөс хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалахад үүсч буй хүндрэлтэй байдал хэвээр үргэлжилнэ.	Зардал гарахгүй боловч асуудлаас үүдэн бий болж байгаа сөрөг үр дагавар үргэлжилнэ.	Үр дүнгүй.
2	Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг	Зорилгод богино хугацаанд шууд хүрэх боломжгүй. Радио соронзон долгионы нөлөөллөөс хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчныг хамгаалах асуудлыг сурталчилгаа хийх замаар тодорхой үр дүнд хүрэх боловч бусад арга хэрэгсэлтэй	Хэвлэл мэдээлэл, олон нийтэд таниулах зорилготой холбоотой сургалт, нэвтрүүлэг ухуулга хийх нэмэлт зардал гарах боловч энэ талаар хийгдэж буй арга	Үр дүнгүй.

	соён гэгээрүүлэх	хавсарсан тохиолдолд зорилгод хүрэх боломжтой.	хэмжээ эерэг үр дагаварыг шууд богино хугацаанд үүсгэжгүй.	
3	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийхэд тодорхой үр дүн гарах боловч бусад арга хэрэгсэлтэй хавсарсан тохиолдолд зорилгод хүрэх боломжтой.	Зардал үр өгөөж тооцох боломжгүй	Үр дүнгүй.
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Асуудал үүссэн гол шалтгаантай холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй.	Зардал, үр өгөөж тооцох боломжгүй	Үр дүнгүй.
	<p>4. Тухайн асуудал Иүссэн шалтгаан, нөхцөл: Радио долгионы тухай хуулинд дэлхийн радио холбооны их хурал, бүсийн бэлтгэл хурлуудад бэлтгэх, санал боловсруулах, радио долгионы улс хоорондын зохицуулалт хийх талаар тодорхой тусгагдаагүй; Радио холбооны шинэ техник, технологийн талаарх судалгаа хангалттай хийгдэхгүй байна; Радио давтамжийн урт болон дунд хугацааны төлөвлөлтийг боловсруулж батлах эрхзүйн орчин байхгүй; Төрийн захиргааны байгууллага нь радио давтамжийн зөвлөл байгуулах болон ажиллах журмыг боловсруулж батлах эрхзүйн зохицуулалт байхгүй;</p>	<p>гаргаснаар олон улсын хурлын шийдвэрүүдэд Монгол Улсын байр суурийг идэвхтэй тусгуулах, шинэ техник технологийн нэвтрэлтийг түргэсгэх, радио давтамжийн менежментийг олон улсын жишигт хүргэх.</p>	<p>эрхзүйн орчинг бий болгох; - Дэлхийн радио холбооны их хурал, бүсийн хурлуудад бэлтгэх, радио долгионы улс хоорондын зохицуулалт хийх; Үндэсний радио давтамжийн менежментийг боловсронгуй болгох болон шинэ техник технологийг нэвтрүүлэх</p>			<p>улсын зохицуулалтын баримт бичгүүдийг тус тус судалсан.</p>	<p>техник технологи, шинэ үйлчилгээг нэвтрүүлснээр шинэ ажлын байр бий болж, улсын төсвийн орлого нэмэгдэн, мэдээлэл харилцаа холбооны дэвшлийг бүх нийтийн хүртээл болгосноор үр өгөөж их байна.</p>	
1	2	3	4	5	6	7	8	9
Асуудал 5. Радио долгионы тухай хуулийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх								
								Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх

Хавсралт-2

ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ,

ХАРЬЦУУЛАЛТ

Хүснэгт 1

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	<b>1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх</b>		
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Ялгаварлан гадуурхсан зохицуулалт байхгүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Үгүй	Ялгаварлан гадуурхсан зохицуулалт байхгүй.
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Нийтийн хэрэглээний радио давтамжийн зохицуулалтын асуудлыг авч үзэж байгаа бөгөөд олон улсын болон үндэсний үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа.
	<b>1.2.Оролцоог хангах</b>		
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Асуудал тус бүрээр бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх нөлөөг тооцсон.
	<b>1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага</b>		
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Хэрэглэгч, хөрөнгө оруулагчдын эрх ашиг хамгаалагдана.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Хүний эрхийн асуудал зөрчихгүй.
1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Хуулийн зорилгыг алдагдуулахаас сэргийлж, хориглох зохицуулалт тусгагдах тул хүлээлгэх хариуцлага бий.	
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Үгүй	Хязгаарлалт тогтоох шаардлагагүй.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын төрний захиргааны болон зохицуулах байгууллага

	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх		Үгүй	Хамааралгүй.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх		Үгүй	Хамааралгүй.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм		Хамааралтай.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм		УИХ, ЗГ, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын төрийн захиргааны болон зохицуулах байгууллага, бүх шатны засаг дарга.
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль днийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх		Үгүй	Хамааралгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм		Жендерээр ялгасан зохицуулалт байхгүй.

Хүснэгт 2

### ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт	Тайлбар	
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Эерэг нөлөө үзүүлнэ.	
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Өрсөлдөөний бодлого, зохицуулалтын орчин оновчтой болсноор дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдэх нөхцлийг бүрдүүлнэ.	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Өрсөлдөөний бодлого, зохицуулалтын орчин оновчтой болсноор дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдэх нөхцлийг бүрдүүлнэ.	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх		Үгүй	Давамгайл байдалтай аж ахуй нэгжийн үнийг хянадаг тул үнийн хөөрөгдөл бий болохгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх		Үгүй	Өрсөлдөөний бодлого, зохицуулалтын орчин оновчтой болсноор



				шудрага, үр дүнтэй өрсөлдөх нөхцлийг бүрдүүлнэ.
3. Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1. Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2. Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Өрсөлдөөний бодлого, зохицуулалтын орчин оновчтой болсноор дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдэх нөхцлийг бүрдүүлнэ.
	3.3. Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4. Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.5. Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4. Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1. Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5. Өмчлөх эрх	5.1. Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2. Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3. Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6. Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1. Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм		Салбарын судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг боловсронгуй болгоно.
	6.2. Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм		Шинэ техник, технологийг нэвтрүүлэхийг дэмжинэ.
7. Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1. Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2. Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.3. Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм		Хэрэглэгчдийн эрх ашиг хамгаалагдана.
	7.4. Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
8. Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	8.2. Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3. Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	9.1. Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

9.Төрийн захиргааны байгууллага	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх		Үгүй	
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм		Радио долгионы асуудлаар Харилцаа холбооны зохицуулах хорооны эрх үүргийг тодорхой болгоно.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		ДНБ-д салбарын эзлэх хувь хэмжээ нэмэгдэнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм		Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

Хүснэгт 3

## НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм		Радио долгион ашигласан шинэ технологи, бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтэрснээр шинээр ажлын байр бий болно.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлж, сайжирна.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм		Радио долгион ашиглагч тоног төхөөрөмжийн нэвтрэлттэй холбоотойгоор.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх		Үгүй	
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм		Салбарын төрийн захиргааны болон зохицуулах байгууллагын чиг үүрэг оновчтой, тодорхой болно.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Уг зохицуулалтыг хийснээр радио долгионоос хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг хязгаарлана.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм		Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

## БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Харнулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохидуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг бууруулах эсэх	Тийм		Холбооны салбарын хөгжил нь тээврийн хэрэгслийн оролцоог багасгадаг.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Холбооны салбарын хөгжил нь тээврийн хэрэгслийн оролцоог багасгадаг.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нооц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм		Радио долгион нь нөхөн сэргээгдэх байгалийн хязгаарлагдмал нөөц баялаг тул уг зохицуулалтыг

				хийснээр ашиглалт сайжрана.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх		Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

\_\_\_\_\_оо\_\_\_\_\_

# РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН

## Нэг.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээний ажлын гол зорилго нь Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн төслийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар найруулах замаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг “Аргачлал батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” /цаашид “Аргачлал” гэх/-д заасны дагуу дараахь үе шаттайгаар хийлээ:

- 1.Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- 2.Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
- 3.Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
- 4.Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

## Хоёр.ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалд заасан 6 шалгуур үзүүлэлтээс дараахь 3 шалгуур үзүүлэлтийг сонголоо:

- 1.Зорилгод хүрэх байдал;
- 2.Ойлгомжтой байдал;
- 3.Харилцан уялдаа.

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зорилго нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцэж байгаа байдал, хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь хуулийн төслийн зорилгод хүрэх боломжтой эсэхийг үнэллээ. Энэхүү үнэлгээг хийхдээ хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага, хуулийн төслийн зорилго болон зорилгод хүрэхэд чиглэгдсэн, мөн түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц арга хэмжээ, зохицуулалтыг сонгож авсан болно.

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг хуулийн төсөл нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх этгээдэд ойлгомжтой, логик дараалалтай томъёологдсон эсэхийг шалгах үүднээс хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн

тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянах байдлаар үнэлгээг хийхээр сонголоо.

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь Монгол Улсын Үндсэн хууль, холбогдох бусад хуульд нийцсэн эсэхийг Аргачлалд заасан асуултад хариулах байдлаар үнэлгээг хийхээр тооцсон болно.

### Гурав.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООЖ, ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ, шаардлагад хуулийн төслийн зорилт, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх үүднээс хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилт, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлалаас үзэхэд радио долгионы давтамжийн хязгаарлагдмал нөөц баялгийг үр ашигтай ашиглах, нийтийн болон тусгай хэрэглээний радио давтамжийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хийх, радио тоног төхөөрөмжийн баталгаажуулалтын тогтолцоог бий болгох, төрийн захиргааны байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хорооны үйл ажиллагааг бэхжүүлэх, төрийн шинэлэг, бүтээлч үйл ажиллагаанд тулгуурлан иргэдийн эрэлт, хэрэгцээг хангасан шинэ төрлийн хэрэглээ, үйлчилгээг нэвтрүүлэх, дэмжих эрх зүйн зохицуулалтыг Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар бий болгох зорилгыг дэвшүүлжээ.

Үр нөлөөг үнэлэхэд тохирох шалгах хэрэгслийг дараахь байдлаар гаргав.

Д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зарим заалт	Зорилго, зорилгод хүрэхэд чиглэгдсэн хуулийн зохицуулалтуудад дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	<u>Ойлгомжтой</u> байдлыг Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу
3	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын дагуу

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ.

**“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн  
хүрээнд хийсэн үнэлгээ**

Хуулийн зорилгод хүрэхэд чиглэгдсэн зохицуулалт болгон Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 3, 4, 6, 7, 8 дахь заалт, 2 дугаар зүйл, 3 дугаар зүйлийн 1, 2 дахь заалтуудыг сонголоо.

**Үр нөлөөг үнэлэхээр сонгосон хуулийн төслийн зохицуулалт**

<b>Хуулийн төслийн зүйл, заалт</b>	<b>Хуульд нэмэлт, өөрчлөлтөөр оруулж байгаа заалт</b>
<p>Төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтаар хуулийн 5.2 дахь хэсэгт 5.2.6-5.2.10 дахь заалт нэмэх, мөн зүйлийн 7 дахь заалтаар хуулийн 15 дугаар зүйлд 2 дахь хэсэг нэмэх, 2 дугаар зүйлээр хуулийн 5.2.5 дахь заалтад нэмэлт оруулах, 3 дугаар зүйлийн 1 дэх заалтаар хуулийн 5.2.3 дахь заалтыг өөрчлөн найруулах.</p>	<p>5.2.Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь радио долгионы талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>5.2.3.радио давтамжийн зурвасыг ашиглах, төлөвлөх, дахин төлөвлөх, хуваарилах болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр тогтоох журам батлах;</p> <p>5.2.5.олон улсын радиогийн байгууллагад Монгол Улсыг төлөөлөх, олон улсын болон бүсийн хуралд бэлтгэх, оролцохтой холбогдсон болон олон улсын гишүүн орнуудаас урьдчилан гаргасан санал, дүгнэлт, судалгааны үр дүнг судлах ажлыг зохион байгуулах;</p> <p>5.2.6.үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт батлах;</p> <p>5.2.7.радио долгионы төлөвлөлтийн бодлого, стратеги, шинэ технологи нэвтрүүлэх, хөгжүүлэхэд баримтлах чиглэл батлах, хэрэгжилтийг хангуулах;</p> <p>5.2.8.хуваарилсан сансрын холбооны хиймэл дагуулын байрлалыг ашиглах талаар санал гаргах;</p> <p>5.2.9.радио давтамжийн хуваарилалтыг төрийн нууцад хамруулах, нууцлалын зэрэглэлийг тогтоох асуудлаар санал гаргах;</p> <p>5.2.10.хуульд заасан бусад бүрэн эрх</p> <p>15.2.Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн нэгдсэн бүртгэлийн журмыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.</p>
<p>Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтаар</p>	<p><b>5<sup>1</sup> дүгээр зүйл. Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрх</b></p>



хуульд 5<sup>1</sup> дүгээр зүйл, мөн зүйлийн 8 дахь заалтаар хуулийн 20 дугаар зүйлд 6 дахь хэсэг нэмэх

5<sup>1</sup>.1.Харилцаа холбооны зохицуулах хороо радио долгионы талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5<sup>1</sup>.1.1.радио долгионы талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, хэрэгжилтэд нь дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;

5<sup>1</sup>.1.2.радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, радио давтамжид баримтлах зохицуулалт, радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норматив баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

5<sup>1</sup>.1.3.улс орны зайлшгүй хэрэгцээ болон техник, технологийн шинэ дэвшлийг нэвтрүүлэхэд шаардагдах радио давтамжийн зурвасын судалгаа хийх, нөөцийг бүрдүүлэх;

5<sup>1</sup>.1.4.Монгол Улсад радио долгионы хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх;

5<sup>1</sup>.1.5.Монгол Улсад бүртгэлтэй болон бүртгүүлэхээр төлөвлөж байгаа радио давтамж, радио давтамжийн зурвасыг олон улсын цахилгаан холбооны байгууллагад бүртгүүлэх;

5<sup>1</sup>.1.6.тусгай хэрэглээнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, зохицуулалтын баримт бичгийг тусгай хэрэглээний радио давтамж ашиглах эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулах;

5<sup>1</sup>.1.7.радио давтамжтай цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшин, хэмжилт хийх аргачлалыг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

5<sup>1</sup>.1.8.хуульд заасантусгайзөвшөөрөл, эрхийн бичиг, тохирлын гэрчилгээолгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, зохицуулалтын баримт бичиг болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;

5<sup>1</sup>.1.9.радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах журам батлах, хяналт тавих;

	<p>5<sup>1</sup>.1.10.хуульд заасан бусад бүрэн эрх.</p> <p>20.6.Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журмыг Зохицуулах хороо баталж, мөрдүүлнэ.</p>
Төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтаар хуульд 8.2-8.4 дэх заалт нэмэх	<p>8.2.Иргэн, хуулийн этгээд тохирлын баталгаагүй радио тоног төхөөрөмж ашиглахыг хориглоно.</p> <p>8.3.Хуульд өөрөөр заагаагүй бол радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах, импортлох, үйлдвэрлэх, худалдахыг хориглоно.</p> <p>8.4.“Радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж” гэж радио холбооны үйлчилгээнд хөндлөнгөөс зориудаар шуугиан үүсгэн дохио дарагч төхөөрөмжийг ойлгоно.</p>
Төслийн 3 дугаарзүйлийн 2 дахь заалтаар хуулийн 14.1.3 дахь заалтыг өөрчлөн найруулах	<p>14.1. Дараахь төрлийн радио төхөөрөмж ашиглахад радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авахгүй:</p> <p>14.1.3.техникийн шаардлага хангасан, тохирлын гэрчилгээтэй богино зайн радио төхөөрөмж.</p>

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтаар хуульд 5<sup>1</sup> дүгээр зүйл нэмэх буюу Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрхийг хуульд нэмж тусгах тухайлбал, Монгол Улсад радио долгионы хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, радио давтамжид баримтлах зохицуулалт, радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норматив баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих зэрэг бүрэн эрхтэй байхаар төсөлд тусгажээ. Мөн төслийн 1 дүгээр зүйлийн 3 дахь заалтаар хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заалтууд нэмж, Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь радио долгионы төлөвлөлтийн бодлого, стратеги, шинэ технологи нэвтрүүлэх, хөгжүүлэхэд баримтлах чиглэл батлах, хэрэгжилтийг хангуулах, радио давтамжийн зурвасыг ашиглах, төлөвлөх, дахин төлөвлөх, хуваарилах болон радио давтамжийн ашиглалт, үйлчилгээний төлбөр тогтоох журам батлах, үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт батлах зэрэг бүрэн эрхтэй байхаар тусгасан байх бөгөөд мөн зүйлийн 7 дахь заалтаар хуулийн 15 дугаар зүйлд Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн нэгдсэн бүртгэлийн журмыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батлах тухай 2 дахь хэсэг нэмэхээр төсөлд тус тус тусгасан нь үзэл баримтлалд заасан нийтийн болон тусгай хэрэглээний радио давтамжийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг хийх, тус салбарын хэм хэмжээ тогтоосон актыг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих байгууллагуудын эрх хэмжээг тодорхой болгох, радио долгионы давтамжийн хязгаарлагдмал нөөц баялгийг үр ашигтай ашиглах эрх зүйн орчныг бий болгох хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

Төслийн 3 дугаар зүйлийн хуулийн 20.3 дахь хэсгийг Зохицуулах хороо нь олон улсын стандартад нийцсэн баталгаажуулалтын лабораторитой байж болохоор өөрчлөн найруулж, төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтаар хуулийн 8 дугаар зүйлд иргэн, хуулийн этгээд тохирлын баталгаагүй радио, тоног төхөөрөмж ашиглахыг хориглохоор, 3 дугаар зүйлийн 2 дахь заалтаар хуулийн 14.1.3 дахь заалтыг техникийн шаардлага хангасан, тохирлын гэрчилгээтэй богино зайн радио төхөөрөмж ашиглах тохиолдолд радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авахгүй байхаар өөрчлөн найруулж байгаа нь хуулийн төслийн үзэл баримтлалд заасан харилцаа холбооны салбарт радио долгион ашиглах цар хүрээ асар хурдтай нэмэгдэж байгаатай холбогдуулан тэдгээрийг зохицуулах, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах, баталгаажуулах хэрэгцээ, шаардлагад нийцэж байна гэж үзлээ.

Түүнчлэн төслийн 1 дүгээр зүйлийн 6 дахь заалтаар хуулийн 8 дугаар зүйлд нэмэлт оруулж, хуульд өөрөөр заагаагүй бол радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах, импортлох, үйлдвэрлэх, худалдахыг хориглохоор тусгасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд заасан радио долгионы давтамжийн хязгаарлагдмал нөөц баялгийг үр ашигтай ашиглах, нийтийн болон тусгай хэрэглээний радио давтамжийн нэгдсэн бодлого, төлөвлөлттэй болох зорилгод нийцсэн байна.

Иймд хуулийн төслийн сонгож авсан заалтууд нь Радио долгионы тухай хуулийн төслийн үзэл баримтлалд заасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг хангасан, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгод хүрэх боломжтой зохицуулалтууд болсон байна гэж үзлээ.

**“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд**

<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>	
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт</b>	<b>Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал</b>
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлагад нийцсэн.
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлагад нийцсэн.
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлагад нийцсэн.
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлагад нийцсэн
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Шаардлагад нийцсэн.

29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлагад нийцсэн.
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлагад нийцсэн.
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлагад нийцсэн.
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Шаардлагад нийцсэн.
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлагад нийцсэн.
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Ийм зүйл шаардлагагүй.
<b>Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлагад нийцсэн.
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлагад нийцсэн.
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлагад нийцсэн.
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлагад нийцсэн.
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлагад нийцсэн.

**“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах”  
шалгуур үзүүлэлтийн хүрээнд**

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Нийцсэн.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	Төсөлд байхгүй.

3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Нийцсэн.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцсэн.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардаагүй.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тусгасан.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Орхигдуулаагүй.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Тусгаагүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Энэ асуудлыг тусгах шаардлагагүй.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Ийм зохицуулалт шаардлагагүй.
11	Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд уг зохицуулалт байгаа, нэмж тусгах шаардлагагүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Тусгаагүй.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Ийм зохицуулалт шаардлагагүй.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Ийм зохицуулалт шаардлагагүй.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Ийм зохицуулалт шаардлагагүй.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Ийм зохицуулалт шаардлагагүй.

### Дүгнэлт, зөвлөмж

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөөг Аргачлалын дагуу тооцож, дараахь дүгнэлтийг гаргаж байна.

1. Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь сонгосон шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд хуулийн төслийн үзэл баримтлалаар тодорхойлсон зорилгыг хангасан, хуулийн төслийн томъёолол нь ойлгомжтой, хоёрдмол утга санаагүй, тодорхой, Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомж болон тухайн хуулийн зүйл, заалттай давхардаагүй, зөрчилдөөгүй гэж дүгнэж байна.

2. Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага болон хуулийн төслийн уялдаа холбоо хангагдсан байна гэж үзлээ.

Ийнхүү Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангаж байгаа тул олон нийтээр хэлэлцүүлэн Засгийн газарт санал авахаар хүргүүлэх зөвлөмжийг санал болгож байна.

---o0o---



ЗАСИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНЦАГ  
**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗАР**  
WWW.ICT.MN

**РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД  
ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ  
2018 ОН**

## **РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦООНЫ СУДАЛГАА**

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал (цаашид “аргачлал” гэх)-ын дагуу тооцов.

Хуулийн төсөл нь Радио долгионы төлөвлөлт, хуваарилалт, олголт, ашиглалт, эзэмшихтэй холбоотой бодлогыг тодорхойлох, бодлогын шийдвэр гаргах тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульчилсан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримталсан болно:

- гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг бодитоор тогтоох;
- бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд 27 хуулийн заалтыг өөрчлөхөөр тусгасан бөгөөд зардал тооцогдох хуулийн заалт тус бүрийн зардалыг тооцоолсон.

### **Нэг. ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦОХ**

Хуулийн этгээдийн зардлыг тооцох ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулсан. Үүнд:

- 1.1. Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 1.2. Зардлыг тооцох;
- 1.3. Тоон үзүүлэлтийг тооцох;
- 1.4. Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 1.5. Хялбарчлах боломжийг шалгах;
- 1.6. Нэмэлт зардлыг тооцох.

**Нэгдүгээр үе шат:** Аргачлалын 2.3-т хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоохдоо хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээдийн гүйцэтгэх үүрэг нэг бүрийг тогтоохоор дурдсан байна.

Гүйцэтгэх үүрэг гэдгийг тухайн хууль тогтоомжийн үйлчлэлд хамаарах хуульд заасны дагуу тоо баримт, тайлан, холбогдох бусад мэдээллийг бэлтгэн төрийн байгууллага буюу гуравдагч этгээдэд гаргаж өгөх, эсхүл хүргүүлэхийг ойлгохоор тусгажээ. Үүнд бүх төрлийн өргөдөл, хүсэлт, маягт бөглөх, статистик тоо мэдээ өгөх, бүртгүүлэх, нөхөн олговор, төрөөс тусламж, дэмжлэг, зөвшөөрөл авахыг хүссэн өргөдөл гаргах, зөвшөөрөл хүсэх гэх мэт үүрэг хамаарна./



Аргачлалд зардлыг тооцохын тулд ажилтны ажлын хөлс, мэдээлэл бэлтгэн гаргахтай холбогдуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний гүйцэтгэлийн хугацааг нэг бүрчлэн тодорхойлох шаардлагатай:

Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн хувьд дараах хуулийн заалтуудыг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүргийг тодорхойлж, зардлыг тооцов:

Хуулийн төсөл дэх холбогдох заалт	Гүйцэтгэх үүрэг
5 <sup>1</sup> .1.8.хуульд заасан тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, тохирлын гэрчилгээ олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, зохицуулалтын баримт бичиг болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих;	<ul style="list-style-type: none"> <li>- Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл шинээр авах</li> <li>- Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах</li> <li>- Радио давтамж ашиглах эрхийн бичиг шинээр авах</li> <li>- Радио давтамж ашиглах эрхийн бичгийн хугацааг сунгуулах</li> <li>- Тохирлын гэрчилгээ шинээр авах</li> <li>- Тохирлын гэрчилгээний хугацааг сунгах</li> </ul>

Хоёрдугаар үе шат: Гүйцэтгэх үүрэг тус бүрийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг тооцох

Хуулийн заалт бүрийн хувьд гүйцэтгэх үүргийг тогтоож, үүргийг хэрэгжүүлэхэд хийгдэх стандарт үйл ажиллагаа тус бүрээр гарган түүнд зарцуулах хугацааг тодорхойлов.

Хуулийн төсөлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд хийгдэх ажиллагааг алхам тус бүрээр тодорхойлон түүнд зарцуулах хугацааг нэг бүрчлэн ажиглалт хийсний үндсэн дээр тодорхойлсон дундаж хугацааг ашигласан болно.

Хүснэгт 1. Хуулийн этгээдээс гарах зардлын тооцоо

Хуулийн заалтын дугаар	Гүйцэтгэх үүрэг	Нэгж зардал	Тоон үзүүлэлт	Дүн /төг/	Тайлбар
5 <sup>1</sup> .1.8	Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл шинээр авах	359,390	49	17,610,110	Жилд 49 байгууллага тусгай зөвшөөрөл шинээр авдаг. Хавсралт 1, Хүснэгт 1.1
	Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах	157,700	64	10,092,800	3 жилд нэг удаа сунгадаг бөгөөд жилд 64 компани сунгуулдаг. Хавсралт 1, Хүснэгт 1.1
	Радио давтамж ашиглах эрхийн бичиг шинээр авах	359,390	112	40,251,680	Жилд 112 байгууллага

				эрхийн бичиг шинээр авдаг. Хавсралт 1, Хүснэгт 1.1
Радио давтамж ашиглах эрхийн бичгийн хугацааг сунгуулах	157,700	158	24,916,600	2 жилд нэг удаа сунгадаг бөгөөд жилд 158 компани сунгуулдаг. Хавсралт 1, Хүснэгт 1.1
тохирлын гэрчилгээ шинээр авах	85,490	59	5,043,910	Жилд 59 тохирлын гэрчилгээ шинээр авдаг. Хавсралт 1, Хүснэгт 1.3
тохирлын гэрчилгээний хугацааг сунгах	45,650	15	684,750	2 жилд нэг удаа сунгадаг бөгөөд жилд 15 тохирлын гэрчилгээ сунгуулдаг. Хавсралт 1, Хүснэгт 1.3
<b>Нийт гарах зардал /төг/</b>			<b>98,599,850</b>	

**Гуравдугаар үе шат:** Тоон үзүүлэлтийг тохиолдлын болон давтагдах тоо ашиглан тооцох

Тохиолдлын тоо буюу арга хэмжээг нэг жилд хэдэн удаа хийгддэг давтагдах тоог гаргахдаа Харилцаа холбооны зохицуулах хорооны 2015-2017 оны тоо баримтыг үндэслэл болгон ашиглав.

**Хүснэгт 2. Хуулийн этгээдээс гарах зардлын тооцоо**

Зөвшөөрлийн төрөл	2015 он	2016 он	2017 он	Дундаж тохиолдлын тоо	Давтагдах тоо
<b>Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл</b>					
Тусгай зөвшөөрөл шинээр хүссэн	41	60	47	49	1 жилд 1 удаа
Тусгай зөвшөөрөл сунгасан, өөрчлөлт оруулсан	95	43	55	64	3 жилд 1 удаа
Тусгай зөвшөөрөл цуцлагдсан	2	9	12	8	1 жилд 1 удаа
Тусгай зөвшөөрлийн нийт тоо	339	271	221	277	
<b>Радио давтамж ашиглах эрхийн бичиг</b>					
Эрхийн бичиг шинээр хүссэн	53	153	130	112	1 жилд 1 удаа

Эрхийн бичиг сунгасан, өөрчлөлт оруулсан	84	199	191	158	2 жилийн дундаж
Эрхийн бичгийн зөвшөөрөл цуцлагдсан	8	7	23	13	1 жилд 1 удаа
Эрхийн бичгийн зөвшөөрлийн нийт тоо	688	610	534	611	
<b>Тохирлын гэрчилгээ</b>					
Тохирлын гэрчилгээ шинээр хүссэн	50	28	100	59	1 жилд 1 удаа
Тохирлын гэрчилгээ сунгасан, өөрчлөлт оруулсан	1	9	34	15	2 жилийн дундаж
Нийт тохирлын гэрчилгээний нийт тоо	72	110	239	140	

2016 оны Монгол Улсын Статистикийн эмхэтгэлд дурдсанаар Мэдээлэл холбооны салбарын үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын ажилтаны 1 сарын дундаж цалин 882,600 төгрөг байна. Үүнийг ажлын 22 өдрөөр тооцвол нэг минутад ноогдох ажлын хөлс 83,57 төгрөг болно.

**Дөрөвдүгээр үе шат:** Нийт зардлын дүнг хүснэгт 1-д тооцсон болно.

**Тавдугаар үе шат:** Хялбарчлах боломжийг шалгахдаа өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах, дарамт, ачааллыг багасгах арга замыг асуултад хариу авах замаар тодорхойлно.

Д/д	Асуулт	Хариулт	Тайлбар
1	Хамрагдах хуулийн этгээдийн тоог багасгах боломж байгаа эсэх	Боломжгүй	Радио давтамж ашиглах зөвшөөрлийн тоо, хамрах хүрээ нэмэгдэж байгаа тул бууруулах боломжгүй.
2	Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх	Боломжгүй	Хуулинд заасан мэдээллийг авдаг тул бууруулах боломжгүй.
3	Мэдээллийн цахимаар хүргүүлэх боломжтой эсэх	Боломжтой	Мэдээллийг цаасаар мөн цахимаар авах боломжтой.
4	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх	Боломжгүй	Хууль тогтоомжийн дагуу хүргүүлдэг тул боломжгүй.

**Нэмэлт зардал:** Хуулийн төслийн хүрээнд өөр бусад /нэмэлт/ зардал шаардсан зүйл байхгүй байна.

#### Дүгнэлт:

Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5<sup>1</sup>.1.8 заалтыг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдээс нийт 98,599,850 (ерэн найман сая таван зуун ерэн есөн мянга найман зуун тавь) төгрөгийн зардал гарахаар тооцов.

Хуулийн этгээдэд хамаарах Радио долгионы тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан дээрх заалт нь одоо

мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудын хүрээнд мөрдөж байгаа тул хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхтэй холбогдсон нэмэлт зардал үүсэхээргүй байна.

### **Хоёр. ИРГЭНД ҮҮСЭХ ЗАРДАЛ**

Нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тусгагдсан хуулийн заалттай холбоотой иргэнээс гарах зардал байхгүй болно.

### **Гурав. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦОХ**

Энэ бүлэгт “Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”-ийн төрийн захиргааны байгууллагад үүрэг оногдуулсан зохицуулалтууд нь тухайн байгууллагад буюу төрд хэдий хэр ачаалал, зардал үүсэх магадлалтайг баримжаалан тооцоолох зорилготой. Төрийн захиргааны байгууллага болон зохицуулах хороонд үүсэх ачаалал, зардлын хэмжээг урьдчилан тооцох нь тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх төсөв, санхүүжилтийн хэмжээ, хэрэгцээ, шаардлагыг тогтоох, мөн хуулийн зохицуулалтын хэрэгжих боломжийг тодорхойлоход нөлөөлөх хүчин зүйлийн нэг юм.

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудлаар төрийн байгууллагад буюу улсын төсөвт үүсэх зардлыг урьдчилсан байдлаар тооцоолох ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан аргачлалын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудлаар төрийн байгууллагад хүлээлгэсэн үүрэг буюу ажил үйлчилгээг тодорхойлох
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох
3. Гарах зардлыг урьдчилан тооцоолох
4. Зардлыг нэгтгэн тооцох
5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

**Нэгдүгээр үе шат: Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох**

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад үүрэг оногдуулсан зохицуулалт орсон.

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр зохицуулж байгаа харилцаа өмнө нь тус хуулиар болон бусад хуулиар зохицуулагдаж байсан бөгөөд нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгагдсан зохицуулалтууд нь бүгд шинээр зохицуулагдаж байгаа харилцаа биш юм.

Мөн Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, зохицуулах хорооны

гүйцэтгэх чиг үүргийг тодорхой тусгах шаардлагатай болсон тул хуулийн төслөөр дэлгэрүүлэн хуульчилсан болно.

Иймд аргачлалын дагуу хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төслөөр шинээр бий болгож байгаа дараах үүргийн хүрээнд гарах зардлыг тооцоолов. Үүнд:

**А. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад үүсэх зардлын тооцоо**

**Хүснэгт 3. Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад үүрэг хүлээлгэсэн заалт**

Хуулийн төсөл дэх холбогдох заалт	Гүйцэтгэх үүрэг
5.2.5. олон улсын радиогийн байгууллагад Монгол Улсыг төлөөлөх, олон улсын болон бүсийн хуралд бэлтгэх, оролцохтой холбогдсон болон олон улсын гишүүн орнуудаас урьдчилан гаргасан санал, дүгнэлт, судалгааны үр дүнг судлах ажлыг зохион байгуулах;	- Судалгаа хийх - Олон улсын хуралд бэлтгэх - Олон улсын хуралд оролцох
5.2.6. үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт батлах;	- Батлах
5.2.7. радио долгионы төлөвлөлтийн бодлого, стратеги, шинэ технологи нэвтрүүлэх, хөгжүүлэхэд баримтлах чиглэл батлах, хэрэгжилтийг хангуулах;	- Батлах - Хэрэгжилтийг хангуулах
5.2.8. Монгол Улсад хуваарилсан сансарын холбооны хиймэл дагуулын байрлалыг ашиглах талаар санал гаргах;	- Санал боловсруулах
5.2.9. радио давтамжийн хуваарилалтыг төрийн нууцад хамруулах, нууцлалын зэрэглэлийг тогтоох асуудлаар санал гаргах;	- Санал боловсруулах

**Хоёрдугаар үе шатны хүрээнд:** Үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох.

1. Үйл ажиллагаа бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд задлан, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд хийгдэх алхам тус бүрээр гарган түүнд зарцуулах хугацааг тодорхойлов.
2. Тохиолдлын тоо буюу уг арга хэмжээг нэг жилд хэдэн удаа хийгддэг талаар тоог гаргахдаа харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын 2013-2018 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг судалгаа болгон ашиглав.
3. Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг гаргав.

Хуулийн төсөлд тусгагдсан чиг үүргийг хэрэгжүүлэхэд хийгдэх ажиллагааг алхам тус бүрээр тодорхойлон түүнд зарцуулах хугацааг нэг бүрчлэн ажиглалт хийсний үндсэн дээр тодорхойлсон дундаж хугацааг ашигласан болно.

### Зардлыг тооцох

Энэ хэсэгт хуулийн төсөлд тусгасан үүргийг хэрэгжүүлснээр харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад үүсэх зардлын хэмжээг хуулийн заалт бүрийн гүйцэтгэх үүргээр задлан, үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхэд стандарт үйл ажиллагааг алхам тус бүрээр гарган түүнд зарцуулах хугацааг тодорхойлсон (Хавсралт 2).

Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагч нь төрийн захиргааны албан хаагчийн цалингийн ТЗ зэрэглэлд хамаардаг тул "Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ"-ний ТЗ-6 зэрэглэлээр дундаж цалингийн хэмжээг тооцож, холбогдох нэмэгдлүүдийг тусган нэг албан хаагчийн нэг жилийн дундаж цалинг 10 408 778 төгрөг байхаар тооцов.

Хүснэгт 4. ТЗ-6 зэрэглэлийн цалингийн хэмжээ

Албан тушаалын зэрэглэл	1	2	3	4	5	Сарын дундаж цалин
ТЗ-6	547 759	580 710	613 669	645 556	677 436	613 023

Хүснэгт 5. Төрийн захиргааны байгууллагад үүсэх зардал

Хуулийн заалт	Нэмэлт өөрчлөлтөөр хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Дундаж зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Нийт зарцуулах хугацаа /мин/	Тайлбар
5.2.5.	Судалгаа хийх	5,340	3	16,020	Хавсралт 2. Хүснэгт 2.1
	Олон улсын хуралд бэлтгэх	7,510	3	22,530	Хавсралт 2. Хүснэгт 2.2
	Олон улсын хуралд оролцох	400	3	1,200	Хавсралт 2. Хүснэгт 2.2
5.2.6	Хүснэгтийг шинэчлэн боловсруулах	5,340	1	5,340	Хавсралт 2. Хүснэгт 2.1
	Батлах	509	1	509	Хавсралт 2. Хүснэгт 2.1
5.2.7.	Бодлогын баримтлах чиглэл боловсруулж, батлах	5,849	3	17,547	Хавсралт 2. Хүснэгт 2.1
	Хэрэгжилтийг хангуулах	1,210	3	3,630	Хавсралт 2. Хүснэгт 2.3
5.2.8.	Судалгаа хийх	5,340	1	5,340	Хавсралт 2. Хүснэгт 2.1
	Санал боловсруулах	5,340	1	5,340	Хавсралт 2. Хүснэгт 2.1
5.2.9	Судалгаа хийх	5,340	1	5,340	Хавсралт 2. Хүснэгт 2.1

Санал боловсруулах	5,340	1	5,340	Хавсралт 2. Хүснэгт 2.1
<b>Нийт гарах зардал</b>	<b>47,518</b>	<b>21</b>	<b>88,136</b>	

Нийт гарсан хугацааг жилийн шаардагдах ажлын цаг болох 96 000 минутад харьцуулбал  $88\ 136 / 96\ 000 = 0.92$  орон тооны ачаалал үүсэхээр байна.

**Гуравдугаар үе шатны хүрээнд:** Зардлын тооцоог хүний нөөцийн, материаллаг, бусад гэсэн зардлын бүрэлдэхүүн хэсгүүдэд хувааж, тэдгээрийн нийлбэрийг гаргасны үндсэн дээр тодорхойлоно.

Өмнөх үе шатанд гаргасан ажиллах шаардлагатай хүний нөөцөд зардлын бусад бүрдлүүдээс оногдох хэсгүүдийн нийлбэрээр уг зардал тооцогдох юм.

Аргачлалд заасны дагуу албан ёсны эх сурвалжаас авсан тоо баримтыг эх сурвалж болгохоор заасан тул материаллаг зардлыг тооцохдоо Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын 2017 оны тоо баримтыг үндэслэсэн бөгөөд нэг албан хаагчид оногдох материаллаг зардал нь мөнгөн дүнгээр 1 292 745 төгрөг байна.

Хүний нөөцийн зардлыг тооцохдоо тус байгууллагын 1 мэргэжилтэнд оногдох зардлыг тооцох бөгөөд харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэргэжилтний хувьд 10 408 778 байхаар тооцсон.

#### Хүснэгт 6. Хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж байгаа ачаалал /орон тоо/	Цалингийн зардал /төг/	Хүний нөөцийн нийт зардал /төг/
Төрийн захиргааны байгууллага	0.92	10 408 778	9 576 075.76

**Дөрөвдүгээр үе шатны хүрээнд:** Нийт дүнг тооцоолох бөгөөд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр нийт зардлыг тооцон гаргана.

Нийт зардал= хүний нөөцийн зардал+ материаллаг зардал.

Үүнээс харахад төрийн байгууллагад үүсэх нийт зардал нь:

$9\ 576\ 075.76 + 1\ 292\ 745 = 10\ 868\ 820.76$  төгрөг байна.

**Тавдугаар үе шатны хүрээнд:** хувилбарыг нягталж, хялбарчлах боломжийг шалгаж, үр дүнг танилцуулах ажлыг энэхүү үе шатанд хийж гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, төсвийн зардлыг багасгах боломж бий эсэх, зохицуулалтын өөр хувилбар байгаа эсэх, ачаалал бууруулах боломжтой эсэхийг тогтооно.

**Хүснэгт 7. Хялбарчлах боломжийн судалгаа**

Д/д	Асуулт	Хариулт	Тайлбар
1	Боловсруулан, батлах журмын тоог багасгах	Боломжгүй	Хуулиар үүрэгжүүлсэн.
2	Судалгааны мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх	Боломжгүй	Судалгаа ач холбогдолгүй болно.
3	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх	Боломжгүй	Хуулиар үүрэгжүүлсэн.
4	Зарим баримт бичгийг боловсруулах хугацааг багасгах боломжтой эсэх	Боломжтой	
5	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх	Боломжгүй	Мэдээллийн хүртээмж буурна.

**Дүгнэлт:**

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт холбогдох заалтуудыг хэрэгжүүлэхэд харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад нийт 10 868 821 (Арван сая найман зуун жаран найман мянга найман зуун хорин нэгэн) төгрөгийн зардал гарахаар тооцов.

**Б. Харилцаа холбооны зохицуулах хороонд үүсэх зардлын тооцоо**

Зохицуулах хорооны зардлыг тооцох ажлыг төрийн байгууллагын зардал тооцохтой адил үе шаттайгаар зохион байгуулсан.

**Нэгдүгээр үе шат:** Зохицуулах хорооны гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох

Аргачлалын дагуу хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд шинээр оруулж байгаа дараах үүргийн хүрээнд гарах зардлыг тооцов. Харилцаа холбооны зохицуулах хорооны хариуцах чиг үүргийн хүрээнд дараах хуулийн заалтуудтай холбоотой гарах зардлыг тооцсон болно.

**Хүснэгт 8. Харилцаа холбооны зохицуулах хороонд үүрэг хүлээлгэсэн заалт**

Хуулийн төсөл дэх холбогдох заалт	Гүйцэтгэх үүрэг
5 <sup>1</sup> .1.1.радио долгионы талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, хэрэгжилтэд нь дүн шинжилгээ хийх, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах	<ul style="list-style-type: none"> <li>- Радио долгионы төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах</li> <li>- Хэрэгжилтэд нь дүн шинжилгээ хийх</li> <li>- Мэдээллээр хангах</li> </ul>



<p>5<sup>1</sup>.1.2.радио давтамж, радио давтамжийн зурвасын хуваарилалт хийх, радио давтамжид баримтлах зохицуулалт, радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норматив баримт бичиг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хуваарилалт хийх, батлах</li> <li>- Зохицуулалтын хийх, батлах</li> <li>- Радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норм, нормативын баримт бичиг батлах</li> <li>- Хэрэгжилтэнд хяналт тавих</li> </ul>
<p>5<sup>1</sup>.1.3.улс орны зайлшгүй хэрэгцээ болон техник, технологийн шинэ дэвшлийг нэвтрүүлэхэд шаардагдах радио давтамжийн зурвасын судалгаа хийх, нөөцийг бүрдүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Радио давтамжийн зурвасын судалгаа хийх</li> <li>- Дэлхийн радиогийн их хурал болон бүсийн хурлуудаар хэлэлцэх радио давтамж, технологийн чилэлийн судалгаа хийх</li> <li>- Нөөцийг бүрдүүлэх</li> </ul>
<p>5<sup>1</sup>.1.4.Монгол Улсад радио долгионы хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсад радио долгионы нэгдсэн хяналтын тогтолцоог бүрдүүлэх судалгааг хийх</li> <li>- Ашиглалтын үйл ажиллагааг зохион байгуулах</li> </ul>
<p>5<sup>1</sup>.1.5.Монгол Улсад бүртгэлтэй болон бүртгүүлэхээр төлөвлөж байгаа радио давтамж, радио давтамжийн зурвасыг олон улсын цахилгаан холбооны байгууллагад бүртгүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> <li>- ХХМТГ-аас батлагдсан журмыг дагуу Радио давтамж, радио давтамжийн зурвасыг олон улсын цахилгаан холбооны байгууллагад бүртгүүлэх</li> </ul>
<p>5<sup>1</sup>.1.6.тусгай хэрэглээнд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, зохицуулалтын баримт бичгийг тусгай хэрэглээний радио давтамж ашиглах эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулах</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Радио давтамжийн зурвасын судалгаа хийх</li> <li>- Хуваарилалт, зохицуулалтын баримт бичгийг боловсруулах</li> </ul>
<p>5<sup>1</sup>.1.7.радио давтамжтай цахилгаан соронзон орны хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшин, хэмжилт хийх аргачлалыг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшин, хэмжилт хийх аргачлалын судалгааг хийх</li> <li>- Аргачлалыг батлуулах</li> <li>- Хэрэгжилтэнд хяналт тавих</li> </ul>
<p>5<sup>1</sup>.1.8.хуульд заасан тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг, тохирлын гэрчилгээ олгох, хугацааг сунгах, тусгай зөвшөөрөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага, зохицуулалтын баримт бичиг болон холбогдох журмыг батлах, гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Журам боловсруулах, батлах</li> <li>- Тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацааг сунгах, нэмэлт, өөрчлөлт оруулах, сэргээх г.м үйл ажиллагаа</li> <li>- Нөхцөл шаардлага, зохицуулалтын баримт бичиг батлах</li> <li>- Биелэлтэд хяналт тавих</li> <li>- Гэрээ байгуулах</li> </ul>
<p>5<sup>1</sup>.1.9.радио холбооны сүлжээ сарниулах тоног төхөөрөмж ашиглах журам батлах, хяналт тавих</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Журам боловсруулах, батлах</li> <li>- Хяналт тавих</li> </ul>

20.3. Зохицуулах хороо нь олон улсын стандартын дагуу баталгаажуулалт хийнэ. Баталгаажуулалтын лабораторитой байж болно.	- Баталгаажуулах радио төхөөрөмжийг сорилт туршилт хийх баримт бичгийг боловсруулах - Холбогдох стандартын дагуу баталгаажуулах, дүгнэлт гаргах
20.6. Радио төхөөрөмж ажиллуулах, үйл ажиллагааг нь зогсоох, хориглох журмыг Зохицуулах хороо баталж, мөрдүүлнэ.	- Журам боловсруулах, батлах - Хяналт тавих, мөрдүүлэх

**Хоёрдугаар үе шат:** Үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох.

Хуулийн заалт бүрийг гүйцэтгэх үүргээр нь задлан, үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийгдэх стандарт үйл ажиллагааг алхам тус бүрээр гарган түүнд зарцуулах хугацааг тодорхойлов (Хавсралт 3).

Зохицуулалтын баримт бичиг боловсруулах ажил, үйлчилгээ нэг бүрийг хуулийн төсөл батлагдсаны дараа хамгийн багадаа жилд 1 удаагийн давтамжтай хийнэ гэж тооцов. Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг гаргав.

**Хүснэгт 9. Харилцаа холбооны зохицуулах хорооноос гарах зардлын тооцоо**

Хуулийн заалт	Гүйцэтгэх үүрэг	Нэгж зардал /мян. төг/	Тоо	Дүн /мян. төг/	Тайлбар
5 <sup>1</sup> .1.1.	Радио долгионы төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, дүн шинжилгээ хийх, Мэдээллээр хангах	1792	1	1792	Хавсралт 3 Хүснэгт 3.1
5 <sup>1</sup> .1.2.	Хуваарилалт хийх, батлах	1427	1	1427	Хавсралт 3 Хүснэгт 3.2 а)
	Зохицуулалтын хийх, батлах	2094	2	4188	Хавсралт 3 Хүснэгт 3.2 б)
	Радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норм, нормативын баримт бичиг батлах	2308	2	4616	Хавсралт 3 Хүснэгт 3.2 в)
	Хэрэгжилтэнд хяналт (зөвшөөрөл тусгах) тавих	245.2	1	245.2	Хавсралт 3 Хүснэгт 3.2 г)
	Хэрэгжилтэнд хяналт (төлөвлөгөөт хяналт) тавих	245.2	3	735.6	Хавсралт 3 Хүснэгт 3.2 г)
5 <sup>1</sup> .1.3.	Радио давтамжийн зурвасын судалгаа хийх, нөөцийг бүрдүүлэх	1930.4	3	5791.2	Хавсралт 3 Хүснэгт 3.3 а)
	Дэлхийн радиогийн их хурал болон бүсийн хурлуудаар хэлэлцэх радио давтамж, технологийн чилэлийн судалгаа хийх	1501.3	2	3002.6	Хавсралт 3 Хүснэгт 3.3 б)
5 <sup>1</sup> .1.4.	Монгол Улсад радио долгионы нэгдсэн хяналтын тогтолцоог бүрдүүлэх судалгааг хийх	1365	1	1365	Хавсралт 3 Хүснэгт 3.4 а)

	Ашиглалтын үйл ажиллагааг зохион байгуулах	120981	1	120981	Хавсралт 3 Хүснэгт 3.4 б)
51.1.5.	ХХМТГ-аас батлагдсан журмыг дагуу Радио давтамж, радио давтамжийн зурвасыг олон улсын цахилгаан холбооны байгууллагад бүртгүүлэх	440	20	8800	Хавсралт 3 Хүснэгт 3.5
51.1.6.	Радио давтамжийн зурвасын судалгаа хийх	1195	1	1195	Хавсралт 3 Хүснэгт 3.6 а)
	Хуваарилалт, зохицуулалтын баримт бичгийг боловсруулах	1849	1	1849	Хавсралт 3 Хүснэгт 3.6 б)
51.1.7.	Хүнд үзүүлэх нөлөөний аюулгүйн түвшин, хэмжилтийг аргачлалын судалгааг хийх	999	2	1998	Хавсралт 3 Хүснэгт 3.7 а)
	Аргачлалыг батлуулах, хэрэгжилтэнд хяналт тавих	591	10	5910	Хавсралт 3 Хүснэгт 3.7 б)
51.1.8.	Журам боловсруулах, батлах	786	1	786	Хавсралт 3 Хүснэгт 3.8.1 а)
	Тусгай зөвшөөрөл шинээр олгох, нэмэлт, өөрчлөлт оруулах	141	49	6909	Хавсралт 3 Хүснэгт 3.8.1 б)
	Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах	94.3	64	6035.2	Хавсралт 3 Хүснэгт 3.8.1 в)
	Тусгай зөвшөөрөл түдгэлзүүлэх	118	5	590	Хавсралт 3 Хүснэгт 3.8.1 г)
	Тусгай зөвшөөрөл сэргээх	110	5	550	Хавсралт 3 Хүснэгт 3.8.1 д)
	Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох	86	13	1118	Хавсралт 3 Хүснэгт 3.8.1 е)
	Нөхцөл шаардлага, зохицуулалтын баримт бичиг батлах	51.1.2. заалт харах			Хавсралт 3 Хүснэгт 3.2 б)
	Гэрээ байгуулах, биелэлтэд хяналт тавих	51.1.2. заалт харах			Хавсралт 3 Хүснэгт 3.2 г)
	Тохирлын гэрчилгээ олгох, сунгах, өөрчлөлт оруулах	213	59	12567	Хавсралт 3 Хүснэгт 3.8.2
	Эрхийн бичиг шинээр олгох	47	112	5264	Хавсралт 3 Хүснэгт 3.8.3 а)
	Эрхийн бичигт өөрчлөлт оруулах, хугацаа сунгуулах	44	158	6952	Хавсралт 3 Хүснэгт 3.8.3 б)
	Эрхийн бичиг хүчингүй болгох	39.3	13	510.9	Хавсралт 3 Хүснэгт 3.8.3 в)
51.1.9.	Журам боловсруулах, батлах	786	1	786	Хавсралт 3 Хүснэгт 3.9 а)
	Хяналт тавих	320	2	640	Хавсралт 3 Хүснэгт 3.9 б)
20.3.	Олон улсын стандартын дагуу баталгаажуулалт хийх	377	59	22243	Хавсралт 3 Хүснэгт 3.10
20.6.	Журам боловсруулах, батлах	786	1	786	Хавсралт 3 Хүснэгт 3.11 а)
	Хяналт тавих, мөрдүүлэх	534	21	11214	Хавсралт 3 Хүснэгт 3.11 б)
Жилийн нийт зардал (мян.төг)				240,846.70	

Харилцаа холбооны зохицуулах хорооны албан хаагчдын 1 сарын дундаж цалин нь 1,383,360 төгрөг бөгөөд ажлын өдрийг 22 гэж тооцвол ажлын нэг өдөрт ноогдох ажлын хөлс нь 62 880 төгрөг болно.

**Гуравдугаар үе шат:** Зардлын тооцоог хүний нөөцийн, материаллаг, бусад гэсэн зардлын бүрэлдэхүүнд хувааж, тэдгээрийн нийлбэрийг гаргасны үндсэн дээр тогтооно.

Материаллаг зардал болон бусад зардлыг нэгдсэн байдлаар Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зардлын тооцоонд хамруулсан болно.

**Дөрөвдүгээр үе шат:** Нийт дүнг тооцоолох бөгөөд хүний нөөцийн зардлыг тооцон гаргасан.

**Нийт зардал = 240 846 700 төгрөг**

**Тавдугаар үе шат:** Хялбарчлах боломжийг шалгахдаа өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах, дарамт, ачааллыг багасгах арга замыг асуултад хариу авах замаар тодорхойлно:

Д/д	Асуулт	Хариулт	Тайлбар
1	Боловсруулан, батлах журмын тоог багасгах	Боломжгүй	Хуулиар үүрэгжүүлсэн.
2	Судалгааны мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх	Боломжгүй	Судалгаа ач холбогдолгүй болно.
3	Шинээр үүсэх үүргийг урьд байсан үүрэгтэй нэгтгэж болох эсэх	Боломжтой	Өмнө нь хийгдэж байсан ажлууд бөгөөд Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэн дэлгэрэнгүй байдлаар хуульчилсан.
4	Зарим баримт бичгийг боловсруулах хугацааг багасгах боломжтой эсэх	Боломжтой	
5	Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх	Боломжгүй	Мэдээллийн хүртээмж буурна.

**Дүгнэлт:**

Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5<sup>1</sup>.1.1, 5<sup>1</sup>.1.2, 5<sup>1</sup>.1.3, 5<sup>1</sup>.1.4, 5<sup>1</sup>.1.5, 5<sup>1</sup>.1.6, 5<sup>1</sup>.1.7, 5<sup>1</sup>.1.8, 5<sup>1</sup>.1.9 болон 20 дугаар зүйлийн 20.3, 20.6 дахь заалтуудыг хэрэгжүүлэхэд нийт **240 846 700** (хоёр зуун дөчин сая найман зуун дөчин зургаан мянга долоон зуун) төгрөгийн зардал гарахаар тооцов.

Дээрх зардал тооцогдсон хуулийн заалтын хүрээнд хийгддэг ажил, үйлчилгээ нь одоогийн Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүргийн хүрээнд хийгддэг бөгөөд Захиргааны ерөнхий хуультай нийцүүлэх зорилгоор илүү нарийвчлан хуульчилсан юм. Иймд хүснэгт 4-т харуулсан тооцоогоор гарсан зардал нь одоо мөрдөж байгаа зардалд багтах учраас улсын төсөвт нэмэлт зардал үүсгэхгүй болно.

## Тав. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлалд заасны дагуу хэмжигдэхүйц зардлыг тооцсон болно. Үүнд:

1. Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 51.1.8 заалтыг хэрэгжүүлэхэд хуулийн этгээдээс нийт **98,599,850** (ерэн найман сая таван зуун ерэн есөн мянга найман зуун тавь) төгрөгийн зардал гарахаар тооцов.

Хуулийн этгээдэд хамаарах Радио долгионы тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан дээрх заалт нь одоо мөрдөгдөж байгаа эрх зүйн актуудын хүрээнд мөрдөж байгаа тул хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлэхтэй холбогдсон нэмэлт зардал үүсэхээргүй байна.

2. Нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд тусгагдсан хуулийн заалттай холбоотой иргэнээс гарах зардал байхгүй болно.

3. Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хүрээнд төрийн байгууллага болох харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хариуцах чиг үүргийг 5 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт холбогдох заалтуудад тусгасан байна. Иймд эдгээр заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг аргачлалын 4.3.3-т заасны дагуу хэмжих боломжтой ажлыг тооцсон бөгөөд хуулийн төслийн заалтуудад заасан ажиллагааг хэрэгжүүлэх зардлыг тооцоход төрийн захиргааны байгууллагад нийт **10 868 821** (Арван сая найман зуун жаран найман мянга найман зуун хорин нэгэн) төгрөгийн зардал гарахаар байна.

Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5<sup>1</sup>.1.1, 5<sup>1</sup>.1.2, 5<sup>1</sup>.1.3, 5<sup>1</sup>.1.4, 5<sup>1</sup>.1.5, 5<sup>1</sup>.1.6, 5<sup>1</sup>.1.7, 5<sup>1</sup>.1.8, 5<sup>1</sup>.1.9 болон 20 дугаар зүйлийн 20.3, 20.6 дахь заалтуудыг хэрэгжүүлэхэд зохицуулах хороонд нийт **240 846 700** (хоёр зуун дөчин сая найман зуун дөчин зургаан мянга долоон зуун) төгрөгийн зардал гарахаар тооцов.

Дээрх зардал тооцогдсон хуулийн заалтын хүрээнд хийгддэг үйл ажиллагаануудыг Харилцаа холбооны зохицуулах хороо нь өнөөгийн бүтэц бүрэлдэхүүний хүрээнд тогтмол хийж байгаа тул энэхүү зардлын тооцоогоор гарсан зардал нь одоо мөрдөж байгаа зардалд багтах учраас улсын төсөвт нэмэлт зардал үүсгэхгүй болно.

Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах нийт зардлыг **350 315 371** (Гурван зуун тавин сая гурван зуун арван таван мянга гурван зуун далан нэгэн) төгрөгийн зардал гарахаар тооцов.

Тус хуулийн төсөл батлагдсанаар гарах зардал нь үр өгөөжтэй харьцуулахад үлэмж бага буюу үр ашиг зардлын харьцаа өндөр байна.

-----oOo-----

**Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр хуулийн этгээдээс  
гарах зардлын тооцоо**

**Хүснэгт 1.1 Хуулийн этгээдийн тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг авах, хугацааг  
сунгуулах, өөрчлөлт оруулах, бүртгүүлэх үйл ажиллагааны зардлын тооцоо**

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Ажлын хөлс /төг/	Зардал /төг/	
Тусгай зөвшөөрөлтэй холбоотой зардал	Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичиг шинээр авах	Холбогдох мэргэжилтнээс мэдээлэл авах	30	83	2,490	
		Өргөдөл бичих	40	83	3,320	
		Маягт бөглөх	60	83	4,980	
		Ашиглах тоног төхөөрөмжид судалгаа хийх	480	83	39,840	
		Санхүүгийн болон техникийн чадавхийн талаарх баримт бичгүүд бүрдүүлэх	1440	83	119,520	
		Холбогдох стандартуудыг судлах	480	83	39,840	
		Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үнийн санал боловсруулах	720	83	59,760	
		Бичиг баримтаа нотариатаар батлуулах	60	83	4,980	
		Хамрах хүрээний тооцоолол хийх	180	83	14,940	
		Шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаагааны бэлэн байдлыг газар дээр нь танилцуулах	480	83	39,840	
		Материалаа холбогдох байгууллагад хүргүүлэх	120	83	9,960	
		Хураамж төлөх	60	83	4,980	
		Гэрээ байгуулах	120	83	9,960	
		Тушаал, шийдвэр, гэрчилгээ, гэрээг хүлээн авах	60	83	4,980	
		<b>Нийт</b>			<b>4330</b>	
	Радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн		Өргөдөл бичих	40	83	3,320
			Маягт бөглөх	60	83	4,980
			Холбогдох баримт бичгийг бүрдүүлэх	480	83	39,840
			Холбогдох стандартуудыг судлах	480	83	39,840

хугацааг сунгуулах	Шаардлагатай тохиолдолд үйл ажиллагаагааны бэлэн байдлыг газар дээр нь танилцуулах	480	83	39,840
	Материалаа холбогдох байгууллагад хүргүүлэх	120	83	9,960
	Хураамж төлөх	60	83	4,980
	Гэрээ байгуулах	120	83	9,960
	Тушаал, шийдвэр, гэрчилгээ, гэрээг хүлээн авах	60	83	4,980
	<b>Нийт</b>	<b>1900</b>		<b>157,700</b>
	<b>Нийт зарцуулах зардал</b>	<b>6230</b>		<b>517,090</b>

Хүснэгт 1.2 Хуулийн этгээдийн тохирлын гэрчилгээ авах, хугацааг сунгуулах, өөрчлөлт оруулах үйл ажиллагааны зардлын тооцоо

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Ажлын хөлс /төг/	Зардал /төг/
Тохирлын гэрчилгээтэй холбоотой үйл ажиллагаа	Баталгаажуулалтын тохирлын гэрчилгээ шинээр авах	Холбогдох мэргэжилтнээс мэдээлэл авах	30	83	2490
		Өргөдөл бичих	40	83	3320
		Маягт бөглөх	60	83	4980
		Холбогдох стандартуудыг судлах	480	83	39840
		Бичиг баримтаа нотариатаар батлуулах	60	83	4980
		Материалаа холбогдох байгууллагад хүргүүлэх	120	83	9960
		Хураамж төлөх	60	83	4980
		Гэрээ байгуулах	120	83	9960
		Тушаал, шийдвэр, гэрчилгээ, гэрээг хүлээн авах	60	83	4980
		<b>Нийт</b>	<b>1030</b>		<b>85490</b>
	Баталгаажуулалтын тохирлын гэрчилгээний хугацаа сунгах	Холбогдох мэргэжилтэнгээс мэдээлэл авах	30	83	2490
		Өргөдөл бичих	40	83	3320
		Маягт бөглөх	60	83	4980
		Бичиг баримтаа нотариатаар батлуулах	60	83	4980
		Материалаа холбогдох байгууллагад хүргүүлэх	120	83	9960
		Хураамж төлөх	60	83	4980
		Гэрээ байгуулах	120	83	9960
		Тушаал, шийдвэр, гэрчилгээ, гэрээг хүлээн авах	60	83	4980
		<b>Нийт</b>	<b>550</b>		<b>45650</b>
		<b>Нийт зарцуулах зардал</b>	<b>1580</b>		<b>131,140</b>

**Хүснэгт 1.3 Хуулийн этгээдийн тайлан, мэдээ хүргүүлэх үйл ажиллагааны зардлын тооцоо**

Үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Ажлын хөлс /төг/	Зардал /төг/
Тайлагнах	Хагас жил тутамд тайлангаа ирүүлэх	Тайланг бэлтгэх	480	83	39,840
		Шуудангаар хүргүүлэх	30	83	2,490
		Шаардлагатай бол нэмэлт мэдээлэл хүргүүлэх	120	83	9,960
	<b>Нийт зарцуулах зардал</b>		<b>630</b>	<b>52,290</b>	



## Хавсралт 2

## Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас гарах зардлын тооцоо

## Хүснэгт 2.1 Судалгаа хийх, бодлогын чиглэл боловсруулах үйл ажиллагааны зардлын тооцоо

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
<b>1. Бодлогын чиглэл боловсруулах</b>				
1	Ажлын хэсэг байгуулах газрын даргын тушаалын төсөл боловсруулж, албажуулах	60	1	60
2	Мэдээлэл цуглуулах	240	1	240
3	Холбогдох статистик мэдээлэл	480	1	480
4	Гадаад улс орнуудын ижил төстэй бичиг баримттай харьцуулсан судалгаа хийх	480	1	480
5	Хамрах хүрээ, салбарын судалгаа хийх	480	1	480
6	Нөлөөлөх орчны судалгаа, анализ хийх	480	1	480
7	Бодлогын баримтлах чиглэл боловсруулах болсон учир шалтгаан тодруулах	480	1	480
8	Эрх зүйн холбогдох баримтуудын нийцлийн судалгаа хийх	480	1	480
9	Бодлогын баримтлах чиглэлийн төсөл боловсруулах	480	1	480
10	Холбогдох газар хэлтсүүдэд танилцуулах, санал авах	240	1	240
11	Үйлчилгээ эрхлэгчдээс санал авахаар хүргүүлэх	240	1	240
12	Санал, дүгнэлт гаргах	240	1	240
13	Судалгааны үндсэн дээр анхны төсөл боловсруулан загварт оруулах	960	1	960
<b>Дүн /боловсруулах/</b>		<b>5,340</b>		<b>5,340</b>
<b>2. Бодлогын чиглэл батлуулах</b>				
1	Газрын Даргын зөвлөлийн хуралд танилцуулах цаг авах	30	1	30
2	Газрын даргын зөвлөлийн хурлын нарийн бичиг хуралдааныг зарлах	10	1	10
3	Газрын даргын зөвлөлийн хурлын бэлтгэл ажил хангах	45	1	45
4	Газрын даргын зөвлөлийн хурлыг хийх	90	1	90
5	Газрын даргын зөвлөлийн хурлаар санал зөрүүтэй, шийдвэрлэх асуудал гарсан бол, саналыг авч нэгтгэн, хуралдааны тэмдэглэл, протокол бичих	150	1	150
6	Бодлогын баримтлах чиглэлийг батлуулах /гарын үсэг, тамга даруулах/	120	1	120
7	Холбогдох байгууллагуудад хүргүүлэх	64	1	64
<b>Дүн /батлах/</b>		<b>509</b>		<b>509</b>
<b>Нийт зарцуулах хугацаа /мин/</b>		<b>5,849</b>	-	<b>5,849</b>

**Хүснэгт 2.2 Олон улсын хуралд бэлтгэх, оролцох үйл ажиллагааны зардлын тооцоо**

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	
1	Ажлын хэсэг байгуулах газрын даргын тушаалын төсөл боловсруулж, албажуулах	60	1	60	
2	Холбогдох мэдээлэл цуглуулах	480	1	480	
3	Гадаад улс орнуудын ижил төстэй ижил бичиг баримттай харьцуулсан судалгаа хийх	Дэлхийн радио холбооны их хурлын хэлэлцэх асуудал	480	1	480
4		ОУЦХБ-ын Радио холбооны товчооны судалгааны ажлын хэсгийн тайлан	480	1	480
5		СРМ (1,2) хурлуудын тайлан	480	1	480
6		Бүсийн бэлтгэл хурлуудын үр дүн (APG 1,2,3,4,5)	480	1	480
7		Бусад бүсийн байгууллагуудын байр суурь (CEPT, RCC, CITELE, ATU, ASMG)	480	1	480
8	Монгол Улсын саналын төсөл боловсруулах	960	1	960	
9	Саналын төслийг ажлын хэсгийн хуралд танилцуулах	480	1	480	
10	Ажлын хэсгээс гарсан санал, дүгнэлтийг тусгах	480	1	480	
11	Судалгааны үндсэн дээр анхны төсөл боловсруулан загварт оруулах	600	1	600	
12	Газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулах цаг авах	10	1	10	
13	Газрын даргын зөвлөлийн хурлын нарийн бичиг хуралдааныг зарлах	30	1	30	
14	Газрын даргын зөвлөлийн хурлын бэлтгэл ажил хангах	240	1	240	
15	Газрын даргын зөвлөлийн хурлыг хийх	90	1	90	
16	Газрын даргын зөвлөлийн хурлаар санал зөрүүтэй, шийдвэрлэх асуудал гарсан бол, саналыг авч нэгтгэн, хуралдааны тэмдэглэл, протокол бичих	480	1	480	
17	Дэлхийн Радиохолбооны их хуралд оруулах Монгол Улсын саналд холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл, чиглэл авах (ГХЯ, ЗГ)	960	1	960	
18	Хуралд төлөвлөгөөний дагуу оролцож, Монгол Улсын саналыг тусгуулах	400	1	400	
19	Хурлын үр дүн, тайланг тухай бүр танилцуулах	240	1	240	
20	Дотоодын радио давтамжийн хуваарилалтын бодлого, зохицуулалтын баримт бичигт тусган ажиллах	Олон баримт бичигт тусгаж ажиллах тул тооцох боломжгүй.			
<b>Нийт зарцуулах хугацаа /мин/</b>		<b>7,910</b>		<b>7,910</b>	

**Хүснэгт 2.3 Хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааны зардлын тооцоо**

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа /мин/	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан ирүүлэх тухай албан бичиг боловсруулах	40	1	40
2	Холбогдох байгууллагуудад хүргүүлэх	30	10	300
3	Байгууллагуудаас ирүүлсэн тайланг нэгтгэх	480	1	480
4	Дүгнэлт гаргах, санал боловсруулах	360	1	360
5	Удирдлагад танилцуулах	30	1	30
<b>Нийт зарцуулах хугацаа /мин/</b>		<b>940</b>	<b>14</b>	<b>1,210</b>

## Харилцаа холбооны зохицуулах хорооноос гарах зардлын тооцоо

Хүснэгт 3.1 радио долгионы талаар төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, дүн шинжилгээ хийх үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийх үйлдэл нэг бүрийг тодорхойлов.

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах дундаж хугацаа /цаг/
1	Үүрэгтэй танилцах, судлах	1
2	УИХ, Засгийн газар, салбарын удирдах байгууллагаас гаргасан мөрийн хөтөлбөр, чиглэл, баримт бичгийг судалгааг хийх	44
2	Радио долгионы хуулийн төслийн 5 <sup>1.1.2</sup> заасан радио давтамжийн хуваарилалт, зохицуулалтын судалгааг судлах, дүгнэлт гаргах	44
3	Радио долгионы хуулийн төслийн 5 <sup>1.1.3</sup> заасан техник, технологийн шинэ дэвшлийг нэвтрүүлэхэд шаардагдах радио давтамжийн зурвасын судалгаа судалгаа судлах, дүгнэлт гаргах	44
4	Радио долгионы хуулийн төслийн 5 <sup>1.1.3</sup> заасан Дэлхийн радиогийн их хурал болон бүсийн хурлуудын тогтоол, шийдвэр болон хэлэлцсэн эх радио давтамж, технологийн чиг хандлагын судалгааг судлах, дүгнэлт гаргах	44
5	Өмнөх 4 төрлийн судалгаа, дүгнэлтэд үндэслэн радио давтамжийн зурвас, радио холбооны үйлчилгээ нэг бүрээр саналын төсөл боловруулах	44
6	Саналын төсөлд холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлэх, санал авах, дахин хянаж, Даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх	6
7	Саналын төслийг ХХМТГ-т албан тоотоор хүргүүлэх	1
<b>Нийт зарцуулах хугацаа /цаг/</b>		<b>228</b>
<b>Зарцуулах ажлын өдөр (нэг ажлын өдрийн 8 цаг)</b>		<b>114</b>
<b>Нэг өдрийн зардал /төг/</b>		<b>62 880</b>
<b>Нийт зардал /мян.төг/</b>		<b>1 792</b>

Хүснэгт 3.2 а) радио давтамж, радио давтамжийн зурвасын хийх, батлах үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийх үйлдэл нэг бүрийг тодорхойлов.

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах дундаж хугацаа /цаг/
1	Үүрэгтэй танилцах, судлах	3
2	Үндэсний радио давтамжийн хүснэгтэд хуваарилсан радио давтамжийн зурвас бүрийн судалгааг хийх	44
3	Радио давтамжийн зурвасын ашиглах технологи, ашиглах радио холбооны үйлчилгээний судалгаа хийх	44
4	Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт болон радио давтамжийн технологийн судалгаанд тулгуурлан тухайн радио давтамжийн зурвасын хуваарилалтын төслийг боловсруулах	44
5	Радио давтамжийн зурвасын хуваарилалтын төсөлд холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлэх, санал авах	20
6	Радио давтамжийн зурвасын хуваарилалтын төсөлд холбогдох байгууллагуудын саналыг тусган дахин хянаж, Даргын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх	12
7	Радио давтамжинд баримтлах зохицуулалтын баримт бичгийн төслийг Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд хэлэлцүүлэх, батлуулах	5
8	ХХЗХ-ны хуралдаанаар батлагдсан "Радио давтамжид баримтлах зохицуулалт"-ын баримт бичгийг холбогдох байгууллага аж ахуйн нэгжид	10

	албан тоотоор хүргүүлэх, хорооны вэйб сайт болон сэтгүүлд хэвлүүлэн олон нийтэд мэдээлэх	
	<b>Нийт зарцуулах хугацаа /цаг/</b>	<b>182</b>
	<b>Зарцуулах ажлын өдөр (нэг ажлын өдрийн 8 цаг)</b>	<b>22.7</b>
	<b>Нэг өдрийн зардал /төг/</b>	<b>62 880</b>
	<b>Нийт зардал /мян.төг/</b>	<b>1 427.0</b>

**Хүснэгт 3.2 б) радио давтамж, радио давтамжийн зурваст зохицуулалт хийх, батлах үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийх үйлдэл нэг бүрийг тодорхойлов.**

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах дундаж хугацаа /цаг/
1	Үүрэгтэй танилцах, судлах	3
2	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын Засгийн газраас баталсан боддлогын чиглэл, холбогдох баримт бичгийн судалгааг хийх	44
3	Үндэсний радио давтамжийн хүснэгтэд хуваарилсан тухайн радио давтамжийн зурвасын хуваарилалтын судалгааг хийх	18
4	Олон улсад тухайн радио давтамжийн зурвасыг ашиглах технологи, радио холбооны үйлчилгээний талаарх 2-3 орны судалгааг хийх	88
5	Тухайн радио давтамжийн зурвасын ашиглалтын байдал, цаашдын хэрэгцээ шаардлагын чиг хандлагыг тогтоох, шийдвэр гаргах	18
6	Гаргасан шийдвэрийг үндэслэн тухайн радио давтамжийн зурвасын ашиглалтын чиглэлийг өөрчлөх, чөлөөлөх хугацааг тогтоох талаар зохицуулалтын төслийг боловсруулах	22
7	Радио давтамжид баримтлах зохицуулалтын төсөлд холбогдох байгууллага, аж ахуйн нэгжээс санал авах	28
8	Радио давтамжид баримтлах зохицуулалтын төсөлд ирүүлсэн санал, хүсэлтийг тусган дахин боловсруулах	10
9	Радио давтамжид баримтлах зохицуулалтын төслийг Даргын зөвлөлд хэлэлцүүлэх	10
10	Радио давтамжинд баримтлах зохицуулалтын баримт бичгийн төслийг Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд хэлэлцүүлэх, батлуулах	6
11	ХХЗХ-ны хуралдаанаар батлагдсан "Радио давтамжид баримтлах зохицуулалт"-ын баримт бичгийг холбогдох байгууллага аж ахуйн нэгжид албан тоотоор хүргүүлэх, хорооны вэйб сайт болон сэтгүүлд хэвлүүлэн олон нийтэд мэдээлэх	20
	<b>Нийт зарцуулах хугацаа /цаг/</b>	<b>267</b>
	<b>Зарцуулах ажлын өдөр (нэг ажлын өдрийн 8 цаг)</b>	<b>33.3</b>
	<b>Нэг өдрийн зардал /төг/</b>	<b>62 880</b>
	<b>Нийт зардал /мян.төг/</b>	<b>2 094.0</b>

**Хүснэгт 3.2 в) Радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норм, нормативын баримт бичиг батлах үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийх үйлдэл нэг бүрийг тодорхойлов.**

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах дундаж хугацаа /цаг/
1	Үүрэгтэй танилцах, судлах	6
2	Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанаар баталсан "Радио давтамжид баримтлах зохицуулалт"-ын баримт бичгүүдийг судлах	18
3	Олон улсад тухайн радио давтамжийн зурвасын талаар гаргасан техник, технологийн нөхцөл, шаардлага болон стандартын байгууллагуудаас гаргасан 5-8 баримт бичгийг судлах	70
4	Судалсан баримтуудаас өөрийн улсын нөхцөл, шаардлага болон техникийн норм, нормативд зайлшгүй тусгах заалт, шаардлагуудыг түүвэрлэн боловсруулалтын материалын мэдээллийн санг үүсгэх	26

5	Радио давтамжийн зурвасын өмнөх ашиглалт болон зохицуулалтын баримт бичгүүдийн шаардлага, норм нормативын баримт бичгийн шинээр боловсруулах болон өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг гаргах	22
6	Радио давтамжийн зурвасын зохицуулалтын болон техник норматив баримт бичгийг боловсруулах	28
7	Радио давтамжийн зурвасын зохицуулалтын болон техник норматив баримт бичгийн төсөлд холбогдох байгууллага, аж ахуйн нэгжээс санал авах	44
8	Радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норм, норматив баримт бичгийн төслийн хэлэлцүүлгийг 1-2 удаа зохион байгуулах	44
9	Хэлэлцүүлгийн үр дүнгээр дахин боловсруулсан "Радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норм, норматив баримт бичиг"-ийн төслийг Даргын зөвлөлийн хурдлаар хэлэлцүүлэх	10
10	Даргын зөвлөлийн санал дүгнэлтийн үндэслэн "Радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норм, норматив баримт бичиг"-ийн төслийг Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанд хэлэлцүүлэх, батлуулах	6
11	ХХЗХ-ны хуралдаанаар батлагдсан "Радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норм, норматив баримт бичиг"-ийг холбогдох байгууллага аж ахуйн нэгжид албан тоотоор хүргүүлэх, хорооны вэйб сайт болон сэтгүүлд хэвлүүлэн олон нийтэд мэдээлэх	20
<b>Нийт зарцуулах хугацаа /цаг/</b>		<b>294</b>
<b>Зарцуулах ажлын өдөр (нэг ажлын өдрийн 8 цаг)</b>		<b>36.7</b>
<b>Нэг өдрийн зардал /төг/</b>		<b>62 880</b>
<b>Нийт зардал /мян.төг/</b>		<b>2 308.0</b>

**Хүснэгт 3.2 г) Хэрэгжилтэнд хяналт тавих үүргийг хэрэгжүүлэхэд хийх үйлдэл нэг бүрийг тодорхойлов.**

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах дундаж хугацаа /цаг/
<b>1. Радио давтамж ашиглах зөвшөөрлийн баримт бичигт тусгах</b>		
1	Үүрэгтэй танилцах, судлах	3
2	Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдаанаар баталсан "Радио давтамжийн зурвасын хуваарилалт", "Радио давтамжид баримтлах зохицуулалтын баримт бичиг", "Радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норм, нормативын баримт бичиг"-ийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд хүргүүлэх, үйл ажиллагаандаа мөрдөхийг үүрэгжүүлэх	12
3	"Радио давтамжийн зурвасын хуваарилалт", "Радио давтамжийн зурвасын зохицуулалт"-ын баримт бичгийг радио давтамжийн олголтын үйл ажиллагаанд мөрдлөгө болгох	10
4	Радио холбооны үйлчилгээтэй холбоотой батлагдсан "Радио төхөөрөмжийн техникийн шаардлага, норм, нормативын баримт бичиг" барим бичгийг тусгай зөвшөөрлийн гэрээний тусгай нөхцөлд тусгуулах	6
<b>Нийт зарцуулах хугацаа /цаг/</b>		<b>31</b>
<b>Зарцуулах ажлын өдөр (нэг ажлын өдрийн 8 цаг)</b>		<b>3.9</b>
<b>Нэг өдрийн зардал /төг/</b>		<b>62 880</b>
<b>Нийт зардал /мян.төг/</b>		<b>245.2</b>
<b>2. Радио давтамж ашиглалтанд төлөвлөгөөт хяналтыг хийх</b>		
1	Үүрэгтэй танилцах, судлах	3
2	Төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамж, чиглэл болон хамрагдах байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн тоог гаргах	10
3	Төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийн дагуу ХХЗХ-ноос батлагдсан радио давтамжийн хуваарилалт, зохицуулалт, техникийн норм, нормативын баримт бичгүүдийн иж бүрдэл болон хэмжүүрийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн бэлтгэл хангах	9

4	ХХЗХ-ноос батлагдсан радио давтамжийн хуваарилалт, зохицуулалт, техникийн норм, нормативын баримт бичгүүдийн мөрдөлтийг хэмжүүрийн тоног төхөөрөмжөөр хэмжилт хийх	12
5	Хэмжилтийн үр дүнгээр тайлан, дүгнэлт гаргах	12
6	Хэмжэлт шалгалтын дүгнэлтийг Даргын зөвлөлийн хурдлаар хэлэлцүүлэх болон баримт бичгийг хэрэгжилтийг хангаагүй байгууллага, аж ахуйн нэгж, иргэн хуулийн дагуу арга хэмжээ авах, шаардлагыг хүргүүлэх	5
7	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс зөрчил дутагдлыг арилгасан тухай хүсэлтийг үндэслэн дахин хэмжилт шалгалтыг хийх	28
8	Байгууллага, аж ахуйн нэгж, иргэнээс зөрчил дутагдлыг арилгаагүй тохиолдолд хуулийн дагуу шийдвэрлэх	6
<b>Нийт зарцуулах хугацаа /цаг/</b>		<b>85</b>
<b>Зарцуулах ажлын өдөр (нэг ажлын өдрийн 8 цаг)</b>		<b>10.6</b>
<b>Нэг өдрийн зардал /төг/</b>		<b>62 880</b>
<b>Нийт зардал /мян.төг/</b>		<b>666.5</b>

Хүснэгт 3.3 а) технологийн шинэ дэвшлийг нэвтрүүлэхэд шаардагдах радио давтамжийн зурвасын судалгаа, нөөцийг бүрдүүлэхэд зайлшгүй хийх үйлдэл нэг бүрийг тодорхойлов.

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах дундаж хугацаа /цаг/
1	Үүрэгтэй танилцах, судлах	3
2	Технологийн онолын үндэслэлийг судлах, Тухайн технологид ашиглаж байгаа радио давтамжийн зурвасуудыг тодорхойлох	24
3	Радио давтамжийн Олон улсын хуваарилалтыг радио давтамжийн зурвас бүрээр гаргах судалгаа	28
4	ОУЦХБ-ын тогтоол (Res), заалт (Art), зөвлөмж (Rec)-уудыг судлах	20
5	Олон улсад уг технологийг ашиглаж байгаа арга туршлагыг судлаж, хамгийн багадаа өөрийн орны нөхцөлтэй ойролцоо 2 орны зохицуулалтын орчныг судлах	48
6	Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийн хуваарилалтыг судлах	10
7	Тухайн радио давтамжийн зурвасуудын нөөцийн болон ашиглалтын судалгаа хийх	18
8	ОХУ болон БНХАУ-тай байгуулсан хилийн бүсийн гэрээг судлах	6
9	Тухайн технологийг нэвтрүүлэхтэй холбоотойгоор үндэсний радио давтамжийн хуваарилалтад өөрчлөлт хийх тухай дүгнэлт хийх	10
10	Тухайн технологийг нэвтрүүлэхтэй холбоотойгоор үндэсний радио давтамжийн зохицуулалт, техникийн стандартад өөрчлөлт хийх, эсвэл шинээр боловсруулах тухай дүгнэлт хийх	14
11	Боловсруулсан судалгааны хэсэг тус бүрийг нэгтгэж, судалгааны тайлан, танилцуулгыг боловсруулах	44
12	Судалгааны тайланг даргын зөвлөлд танилцуулах	3
13	Тайлангийн талаар байгууллагын веб хуудсан мэдээлэл бэлтгэх	9
14	Судалгааны тайлангийн талаар сэтгүүлд мэдээлэл бэлтгэх	9
<b>Нийт зарцуулах хугацаа /цаг/</b>		<b>246</b>
<b>Зарцуулах ажлын өдөр (нэг ажлын өдрийн 8 цаг)</b>		<b>30.7</b>
<b>Нэг өдрийн зардал /төг/</b>		<b>62 880</b>
<b>Нийт зардал /мян.төг/</b>		<b>1 930.4</b>

Хүснэгт 3.3 б) Дэлхийн радиогийн их хурал болон бүсийн хурлуудаар хэлэлцэх радио давтамж, технологийн чилэлийн судалгааг хийх үйлдэл нэг бүрийг тодорхойлов.

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах дундаж хугацаа /цаг/
1	Үүрэгтэй танилцах, судлах	5
2	Радио давтамийн зурвасын талаар гаргасан дэлхийн радиогийн их хурлын шийдвэр, ОУ-ын байгууллагуудын хийсэн судалгаа, тайлангаар мэдээллийн сан үүсгэх	20
3	Мэдээллүүдийг судлаж, радио давтамжийн хуваарилалтын улс орнуудын байр суурийг харьцуулсан судалгаа хийх	44
4	Радио давтамжийн Олон улсын хуваарилалт болон үндэсний хуваарилалтын хүснэгт туссан радио давтамжийн зурвас бүрээр гаргах судалгаа	18
6	Хэлэлцэх асуудалд ОУЦХБ-ын 1 бүсийн RCC болон 3-р бүсийн АРТ-ийн, ОХУ ба БНХАУ-ын байр суурийг судлаж дүгнэлт хийх	26
8	Радио давтамжийн хуваарилалтын хэлэлцэх асуудал тус бүрт өөрийн орны нөхцөл байдлыг судалж дүгнэлт хийх	20
10	Судалгаануудыг нэгтгэж, боловсруулан тайлан гаргах	18
11	Тайланг даргын зөвлөл болон ДРИХ-д бэлтгэх ажлын хэсгийн хуралдаанд танилцуулах	5
16	Боловсруулсан саналд шаардлагатай тохиолдолд завсар оруулах	3
17	Боловсруулсан саналыг төрийн захиргааны төв байгууллагад албан тоотоор илгээх	3
18	Боловсруулсан саналыг хэрэв ДРИХ-д оруулах санал бол гадаад явдлын яаманд албан тоотоор илгээж зөвшөөрөл авах	9
21	ДРИХ-аас гарсан шийдвэр болон Радио холбооны дүрэмд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг судалж, үндэсний радио давтамжийн төлөвлөлт, хуваарилалтад өөрчлөлт оруулах	20
Нийт зарцуулах хугацаа /цаг/		191
Зарцуулах ажлын өдөр (нэг ажлын өдрийн 8 цаг)		23.8
Нэг өдрийн зардал /төг/		62 880
Нийт зардал /мян.төг/		1 501.3

Хүснэгт 3.4 а) Монгол Улсад радио долгионы нэгдсэн хяналтын тогтолцоог бүрдүүлэх судалгааг хийх үйлдэл нэг бүрийг тодорхойлов.

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах дундаж хугацаа /цаг/
1	ОУЦХБ-ын зөвлөмж, Спектр хяналтын гарын авлага номонд заасан шаардлагыг нарийвчлан судлах	5
2	Олон улсад хэрэгжүүлж байгаа арга хэлбэрийг судлах	15
3	Өөрийн орны онцлогт тохируулан боломжит хувилбар, иж бүрдэлийг тооцон гаргах	13
4	Ашиглагдаж байгаа төхөөрөмжтэй нийцүүлэн ашиглах боломжийг тодорхойлно	2.5
5	Сонгосон хувилбарт шаардагдах тоног төхөөрөмжүүдийн техник үзүүлэлтүүдийг судлан сонгох	16
6	Тэдгээрийг нэгдсэн систем болгон хооронд нь уялдуулан ажиллуулахад ашиглах программ хангамжийн боломж, хүчин чадлыг судлах	15
7	Тоног төхөөрөмж, программ хангамж бусад зүйлсийн үнийн судалгаа хийх	22
8	Радио долгионы хяналтын тогтолцоог хөгжүүлэх хэтийн төлөвлөлт боловсруулан Даргийн зөвлөл болон ХХЗХ-ны хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах	12

9	Батлуулсан төлөвлөлтийн дагуу тухайн оны төсөвт шаардагдах зардалыг тусган батлуулах	4
10	Боломжит төсөвт өртөгт багтаан худалдан авалт хийх төхөөрөмжийн эцсийн хувилбар сонголтыг хийх	13
11	Холбогдох журмын дагуу худалдан авалтад шаардлагатай бичиг баримтыг боловсруулна	7
12	Бараа нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад оролцох	3
13	Шалгарсан нийлүүлэгчтэй хийгдэх гэрээ хэлцэлд тодруулга санал оруулах	1.5
14	Нийлүүлсэн тоног төхөөрөмжийг тендерийн нөхцөл шаардлагын дагуу шалган хүлээн авах	15
15	Хүлээн авсан төхөөрөмжийн программ хангамжид шаардагдах спектр менежментийн бүртгэл судалгааны өгөгдлийн санг бүрдүүлэх	7
16	Бүрдүүлсэн өгөгдлийн санг программ хангамжид нийцүүлэн оруулах	14
17	радио долгионы нэгдсэн хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсгэврийг бүрдүүлэх зорилгоор гадны улс орнуудын зохих байгууллагуудад өөрийн төсөл төлөвлөгөө, хүсэлтийг илгээн танилцуулах	9
<b>Нийт зарцуулах хугацаа /цаг/</b>		<b>174</b>
<b>Зарцуулах ажлын өдөр (нэг ажлын өдрийн 8 цаг)</b>		<b>21.7</b>
<b>Нэг өдрийн зардал /төг/</b>		<b>62 880</b>
<b>Нийт зардал /мян.төг/</b>		<b>1 365.0</b>

*Хүснэгт 3.4 б) Монгол Улсад радио долгионы нэгдсэн хяналтын тогтолцоог ашиглах үүргээ хэрэгжүүлэхэд зайлшгүй хийх үйлдэл нэг бүрийг 2017 оны хяналтын гүйцэтгэлийн тайлангаар тодорхойлов.*

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах дундаж хугацаа /цаг/	Давталт	Оролцох хүний тоо	Гүйцэтгэх дундаж утга
1	Шинээр ирсэн тоног төхөөрөмжийн ажиллагааны зааврыг судлан эзэмших	4	2	9	72
2	Шаардлагатай хэмжилт хийхэд ашиглах тоног төхөөрөмж антенны иж бүрдэл сонголт хийж ажилд бэлтгэх	1	108	8	1728
3	Хөдөлгөөнт хяналт хийх тохиолдолд хэмжилт хийх газраа хүрч очих	2	50	2	200
4	Орон нутагт томилолтоор ажиллан хийгдэх хэмжилт шалгалтыг гүйцэтгэх	120	8	2	1920
5	Хуулийн хэрэгжилтийг хангуулах үүднээс хийгдэх хэмжилт шалгалт хийх	8	23	3	552
6	Радио давтамжийн өргөн зурваст төрөл бүрийн үйлчилгээний ашиглалтын байдалд хяналт тавихад ашиглах	6	200	2	2400
7	Уул уурхай, барилга, такси тээвэрийн хэрэгслийн зэрэг бусад салбаруудад ашиглагдаж байгаа радио давтамжийн хэрэглээнд хяналт тавих	50	5	3	750
8	Үүрэн холбооны үйлчилгээний хүртээмж чанар байдалд хяналт тавих хэмжилт хийх	40	25	2	2000
9	Радио өргөн нэвтрүүлгийн хамрах хүрээ, үйлчилгээний чанарт хяналт тавих	8	25	2	400
10	Тоон телевизийн өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний чанар хүртээмжид хяналт тавих	16	25	2	800
11	Радио давтамж хоорондын харилцан нөлөөллийн шалтгааныг илрүүлэн арилгах	20	30	1	600



12	Өргөн зурвасын утасгүй интернэтийн давтамжийн зурваст хяналт тавих	8	30	1	240
13	Хэрэглэгч, үйлчилгээ эрхлэгчидийн хүсэлт, гомдлын дагуу хэмжилт шалгалт хийх	8	108	1	864
14	Тоног төхөөрөмжийг суурин ашиглах тохиолдолд антенныг холбон, тэжээлд залган ажиллагааг эхлүүлэх	2	108	1	216
15	Шаардлагатай хэмжилтийг хийж гүйцэтгэх	6	108	1	648
16	Хэмжилт бүрийн үр дүнг тухайн төхөөрөмжийн санах ойд хадгалах буюу фото зураг болгон баримтжуулах	1	200	1	200
17	Хэмжилтийн үр дүнд дүн шинжилгээ хийж боловсруулах	2	200	1	400
18	Хэмжилтэнд ашигласан тоног төхөөрөмжийн иж бүрдэлийг шалган, үзлэг цэвэрлэгээг хийж хадгалах байранд тавих	2	108	1	216
19	Үр дүнг үндэслэн дүгнэлт гаргах тайлан бичих буюу баримт бичиг боловсруулах	8	108	1	864
20	Шаардлагатай тохиолдолд албан бичиг боловсруулан илгээх	1	108	1	108
21	Ажлын үр дүнг удирдлагад танилцуулах	2	108	1	216
<b>Нийт зарцуулах хугацаа /цаг/</b>		<b>315</b>			<b>15 394</b>
<b>Зарцуулах ажлын өдөр (нэг ажлын өдрийн 8 цаг)</b>					<b>1924</b>
<b>Нийт 9 ажилтан хамтран гүйцэтгэдэг тул нэг хүнд ноогдох ажлын өдөр</b>					<b>213.8</b>
<b>Нэг өдрийн зардал /төг/</b>					<b>62 880</b>
<b>Нийт зардал /мян.төг/</b>					<b>120 981.0</b>
<i>"Монгол Улсад радио долгионы нэгдсэн хяналтын тогтолцоог бүрдүүлэх" үйл ажиллагаа нь олон хүний хамтарсан үйл ажиллагааны үр дүнд хэрэгжих онцлогтой тул тусгайлан хүн нэг бүрээр тооцоолох боломжгүй учир 2017 оны ажлын гүйцэтгэлд үндэслэн үйлдэл нэг бүрээр гарган тооцоолов.</i>					

**Хүснэгт 3.5 Үүргээ хэрэгжүүлэхэд зайлшгүй хийх үйлдэл нэг бүрийг тодорхойлов.**

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах дундаж хугацаа /цаг/
1	Үүрэгтэй танилцах, судлах	2.5
2	Бүртгүүлэх мэдээлэлтэй холбоотой мэдээллийг цуглуулах	22
3	Мэдээллийн иж бүрдлийг шалгах	15
4	Мэдээлэл, өгөгдөхүүнийг нягтлах	2.5
5	Нэмэлт мэдээллийг шаардлагатай эсэхийг шалгах	2
6	Бүртгүүлэх мэдээлэлтэй холбоотой мэдээллийг боловсруулах	2.5
7	Бүртгүүлэх мэдээлэлтэй холбоотой мэдээллийг удирдах албан тушаалтнаар /газрын даргаар/ хянуулах	3.5
8	Бүртгүүлэх мэдээллийг Олон улсын цахилгаан холбооны байгууллагын маягаар бөглөх, тэмдэглэх	1.5
9	Олон улсын цахилгаан холбооны байгууллагад илгээх	1
10	Бүртгэсэн эсэх болон бүртгэлээс татгалзсан хариу авах	1.5
11	Татгалзсан тохиолдолд шалтгааныг тогтоох, дутуу мэдээллийг гүйцээх, эсвэл бүртгэлийг дахин эхлүүлэх	3

Нийт зарцуулах хугацаа /цаг/	57
Зарцуулах ажлын өдөр (нэг ажлын өдрийн 8 цаг)	7
Нэг өдрийн зардал /төг/	62 880
Нийт зардал /мян.төг/	440.2

Хүснэгт 3.6 а) Радио давтамжийн зурвасын хуваарилалтын судалгааг хийх, боловсруулах үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийх үйлдэл нэг бүрийг тодорхойлов.

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах дундаж хугацаа /цаг/
1	Үүрэгтэй танилцах, судлах	3
2	Тусгай хэрэглээний байгууллагуудаас (цаашид ТХБ гэх) ашиглах радио давтамжийн судалгааг авах албан тоот явуулах	6
3	ТХБ ирүүлсэн хүсэлтийг судлах	12
4	Радио давтамжийн Олон улсын хуваарилалтыг судлах	12
5	Санал болгосон радио давтамжийн зурвасын Олон улсад ашиглагдаж буй техник технологийн судалгааг хийх	6
6	Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийн хуваарилалтыг судлах	32
7	Тухайн радио давтамжийн нөөцийн болон ашиглалтын судалгаа хийх	12
8	ОХУ болон БНХАУ-тай байгуулсан хилийн бүсийн гэрээг судлах	12
9	Радио давтамжийн зурвасын хуваарилах стандарт, сувгийн өргөн болон ТХБ-ын хэрэгцээ шаардлагыг хангах эсэх дүгнэлт гаргах	32
10	Радио давтамжийн нөөцийн боломжтой радио давтамжийн зурвасуудын талаар болон нөөцийн боломжгүй зурвасуудын талаар ТХБ-аар хэлэлцүүлэх	13
11	Хэлэлцүүлгийн үр дүнгээр боломжит радио давтамжийн зурвасыг батлуулахаар холбогдох газарт хүргүүлэх	12
	<b>Нийт зарцуулах хугацаа /цаг/</b>	<b>152</b>
	<b>Зарцуулах ажлын өдөр (нэг ажлын өдрийн 8 цаг)</b>	<b>19</b>
	<b>Нэг өдрийн зардал /төг/</b>	<b>62 880</b>
	<b>Нийт зардал /мян.төг/</b>	<b>1 195.0</b>

Хүснэгт 3.6 б) Радио давтамжийн зурвасын зохицуулалтын баримт бичгийг хамтран боловсруулах үүргийг хэрэгжүүлэхэд зайлшгүй хийх үйлдэл нэг бүрийг тодорхойлов.

д/д	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах дундаж хугацаа /цаг/
1	Үүрэгтэй танилцах, судлах	3
2	Тусгай хэрэглээний байгууллагуудаас (цаашид ТХБ гэх) ашиглах радио давтамжийн судалгааг авах албан тоот явуулах	6
3	ТХБ ирүүлсэн хүсэлтийг судлах	12
4	Радио давтамжийн Олон улсын хуваарилалтыг судлах	12
